



ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2025-2028 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төлөвлөгөөг баталсан:

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Төсвийн ерөнхийлөн захирагч

/Н.УЧРАЛ/

2025.01.16

Төлөвлөгөөг тайлагнасан:

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ,
ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА

Төсвийн төвлөрүүлэн захирагч

/А.ЭНХМАНЛАЙ/

2025.01.16



НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1.Зорилго, зорилт: Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн салбарын хөгжлийн хандлага, 2025-2028 онд баримтлах стратегийн бодлогыг тодорхойлох хэрэгжүүлэх арга хэмжээний үндсэн чиглэлийг гаргахад энэ төлөвлөгөөний зорилго оршино. Уг зорилгод хүрэхийн тулд дараах зорилтыг дэвшүүлж төлөвлөгөөнд тусгалаа:

- Газар, зохион байгуулалт, геодези, зураг зүйн салбарын өнөөгийн тулгамдсан асуудалд үнэлэлт, дүгнэлт өгөх, дүн шинжилгээ хийх;
- Хуулиар хүлээсэн чиг үүрэг, эрх хэмжээний хүрээг тодорхойлох мандатын шинжилгээ хийх, ерөнхий чиг үүрэг, үндсэн чиг үүрэг, дэд чиг үүргийг тодорхойлох;
- Салбарын хөгжлийн өнөөгийн байдалд SWOT шинжилгээ хийж, давуу болон сул талыг эрэмбэлэх;
- Салбарын стратегийн зорилт, зорилтыг тодорхойлж, уялдаа холбоог судлах, суурь түвшин, шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг тооцох;
- Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, хүрэх түвшин, үнэлэх шалгуур үзүүлэлтийг тодорхойлох;
- Шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг тооцох;
- Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад оролцогч талуудын зохион байгуулалт, үйл ажиллагааны уялдааг тодорхойлох.

1.2.Стратегийн төлөвлөгөө боловсруулахад баримталсан зарчим: Төлөвлөгөөг ухаалаг буюу зорилго тодорхой, хэмжиж болохуйц, зорилгодоо хүрч болохуйц, бодитой, цаг хугацаатай байх зарчмуудад үндэслэн боловсруулав.

1.3.Стратеги төлөвлөгөөний хамрах хүрээ: Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар, түүний харьяа аймаг, нийслэл дэх газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг нэгдмэл байдлаар төлөвлөн, хэрэгжүүлэхээр тодорхойлов.

1.4.Салбарын 2020-2024 оны стратеги төлөвлөгөөний хэрэгжилт, сургамж:

2021 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн БХБЯ-ны тушаалын дагуу ГЗБГЗЗГ-ын одоогийн ГЗБГЗЗЕГ-ын 2021-2024 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөг 52 зорилт, 116 арга хэмжээтэй баталсан. Тус стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг ГЗБГЗЗЕГ-ын 2021-2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланг үндэслэн дараах дүгнэлтийг боловсруулав. Тус 52 зорилт бүхий стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэн үзэхэд биелэлт 90-100 хувийн биелэлттэй 33 зорилт, 70-90 хувийн биелэлттэй 11 зорилт, 70 доош хувийн биелэлттэй 5 зорилт байна. Үүнээс үндэслэн стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг 89.3 хувийн биелэлттэй байна.

1.5.Стратеги төлөвлөгөө боловсруулах хэрэгцээ, шаардлага: Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын

урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, 2020 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” болон 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Засгийн газрын 2024-2028 оны үйл

ажиллагааны мөрийн хөтөлбөр"-т тусгагдсан газар зохион байгуулалт, геодези, зураг зүй, орон зайн өгөгдлийн дэд бүтцийн хүрээний стратегийн зорилт, арга хэмжээнүүдийг 2025-2028 онд хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага үүссэн.

Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор батлагдсан "Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам"-ын 2.3-т "Яамны харьяа агентлаг нь байгууллагын стратеги төлөвлөгөөг боловсруулан салбарын сайдаар, аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх агентлаг аймаг, нийслэлийн Засаг даргаар тус тус батлуулан, хэрэгжилтийг зохион байгуулна." гэж заасны дагуу Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар /цаашид "агентлаг" гэх/-ын үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөг Монгол Улсын хуулиуд, Улсын Их Хурал, Засгийн газрын бодлого, зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд боловсрууллаа.

1.6.Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлснээр хүрэх үр дүн: Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын 2025-2028 оны стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлснээр Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдийг хуулиар олгогдсон чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэх арга замыг тодорхойлон, газрын харилцааны ил тод, тогтвортой, үр ашигтай тогтолцоог бүрдүүлэх нөхцөл бүрдэнэ.

ХОЁР. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо		47
Үүнээс:	Тухайн салбарын хуулийн тоо	8
	Нийтлэг мөрддөг хуулийн тоо	39
Ерөнхий чиг үүрэг: Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн салбарын бодлогыг хэрэгжүүлэх		
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
ҮЧҮ-1: Салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгох;	ДЧҮ-1.1: Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх;	ЗГХЭГ, яамд, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, хувийн хэвшил, иргэд
	ДЧҮ-1.2: Холбогдох хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг боловсруулах, санал авах, олон нийтээр хэлэлцүүлэх, эрх бүхий байгууллагад өргөн барих, батлуулах ажлыг зохион байгуулах;	
ҮЧҮ-2: Геодези, зураг зүйн бодлогыг хэрэгжүүлэх;	ДЧҮ-2.1: Геодезийн цэг тэмдэгтийн нэгдсэн тогтолцоо, сүлжээг байгуулах;	
	ДЧҮ-2.2: Геодези, зураг зүйн үйл ажиллагааны үндэс болох солбицол, өндөр, тусгаг, масштаб, дүрслэх хавтгайн тогтолцоог боловсруулж хэрэгжүүлэх;	
	ДЧҮ-2.3: Геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн санг бүрдүүлэх;	

	ДЧҮ-2.4: Геодези, зураг зүйн хэмжлийн багаж хэрэгслийг шалгах, баталгаажуулах;	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын холбогдох хэлтсүүд, Нийслэл, дүүргийн газар зохион байгуулалтын алба, 21 аймгийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, газрын даамал
	ДЧҮ-2.5: Монгол Улсын нутаг дэвсгэрийг зурагжуулах төрийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх;	
	ДЧҮ-2.6: Газар зүйн нэрийн жагсаалт зохиох, толь бичиг, лавлах боловсруулж хэвлэх, нэрийг зөв бичих, шинээр өгсөн нэр болон нэрийн өөрчлөлтийн бүртгэл хөтлөх, газрын зурагт тусгах	
	ДЧҮ-2.7: Геодези, зураг зүйн заавар, дүрэм батлах, стандартыг боловсруулж мөрдүүлэх;	
	ДЧҮ-2.8: Олон улсын гэрээгээр геодези, зураг зүйн асуудлаар Монгол Улсын хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээ авах;	
ҮЧҮ-3: Газар зохион байгуулалтын бодлогыг хэрэгжүүлэх;	ДЧҮ-3.1: Иргэдэд газар өмчлүүлэх талаархи төрийн нэгдсэн бодлогыг улсын хэмжээнд хэрэгжүүлэх;	Газар зохион байгуулалтын орон тооны бус мэргэжлийн зөвлөл, Газар зохион байгуулалт, газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллагын эрхтэй хуулийн этгээд Бүх шатны шүүх
	ДЧҮ-3.2: Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, батлуулах;	
	ДЧҮ-3.3: Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө болон сум, нийслэл, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөлд дүгнэлт өгөх, хэрэгжилтэд хяналт тавих;	
	ДЧҮ-3.4: Улсын хэмжээнд газар зохион байгуулалтын үйл ажиллагааг эрхлэх	
	ДЧҮ-3.5: Улсын тусгай хэрэгцээний газрын газар зохион байгуулалтыг эрхлэх;	
	ДЧҮ-3.6: Иргэдэд өмчлүүлэх газрын байршил, зориулалт, хэмжээний талаар аймаг, нийслэлийн Засаг даргаас ирүүлсэн саналыг нэгтгэх, өмчлүүлэх газрын байршил, зориулалт, хэмжээ, заагийг сум, дүүрэг тус бүрээр нэгтгэн бүртгэх	
ҮЧҮ-4: Улсын хэмжээнд газрын кадастрын бодлого боловсруулж, хэрэгжүүлэх, улсын газрын мэдээллийн санг бүрдүүлэх, хөтлөх;	ДЧҮ-4.1: Газрын мэдээллийн улсын санг бүрдүүлэх, хөтлөх, нийтэд үйлчлэх үйл ажиллагааг зохицуулах	
	ДЧҮ-4.2: Аж ахуйн нэгж, байгууллага, иргэний эдлэн газрыг бүртгэлд хамруулан, лавлагааны нэгдсэн зургийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээр хөтлөх;	
	ДЧҮ-4.3: Бүх ангиллын кадастрын зураглалын стандарт, технологийн аргачлал, дүрэм, журмыг батлуулан мөрдүүлэх;	

	ДЧҮ-4.4: Газрыг эзэмшил, эсхүл ашиглалтад олгосноос үл хамааруулан газрын тоо бүртгэлийг нэгдмэл сангийн хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж бүрээр хөтөлж, газрын мэдээллийн улсын санд оруулах;	
	ДЧҮ-4.5: Газрын нэгдмэл сангийн тооллого, тоо бүртгэлийг улсын хэмжээнд хөтлөх, газрын нэгдмэл сангийн ангиллын өөрчлөлт, шилжилт хөдөлгөөнийг бүртгэх, хяналт тавих, Газрын нэгдмэл сангийн мэдээллийн системийг эрхлэх;	
	ДЧҮ-4.6: Газрын нэгдмэл сангийн болон газрын тайланг жил бүр нэгтгэн Засгийн газарт танилцуулах;	
	ДЧҮ-4.7: Газар, үл хөдлөх, эд хөрөнгийн хаягийг кадастрын мэдээллийн санд бүртгэж, баталгаажуулах, хаягийн мэдээллийн нэгдсэн системийг эрхлэх;	
	ДЧҮ-4.8: Улсын хот байгуулалтын кадастрын нэгдсэн системийг эрхлэх удирдан зохион байгуулах;	
	ДЧҮ-4.9: Газрын зөрчил маргааныг бууруулах арга хэмжээг зохион байгуулах;	
ҮЧҮ-5: Газрын биржийн үйл ажиллагааг зохион байгуулах;	ДЧҮ-5.1: Газрын чанарын үнэлгээ хийх аргачлал, үзүүлэлтийг батлах, Газрын эдийн засгийн үнэлгээ хийх аргачлалыг боловсруулах Засгийн газраар батлуулах;	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын холбогдох хэлтсүүд, Нийслэл, дүүргийн газар зохион байгуулалтын алба, 21 аймгийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, газрын даамал Газар зохион байгуулалтын орон тооны бус мэргэжлийн зөвлөл, Газар зохион байгуулалт, газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллагын эрхтэй хуулийн этгээд Бүх шатны шүүх
	ДЧҮ-5.2: Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны анхны үнийг тодорхойлох аргачлалыг батлах;	
	ДЧҮ-5.3: Газрын биржийн үйл ажиллагааг зохих журмын дагуу зохион байгуулах;	
	ДЧҮ-5.4: Газрын төлбөрийн хэмжээ, түүнийг хөнгөлөх, чөлөөлөх, зарцуулах журмыг боловсруулах, батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих;	
ҮЧҮ-6: Газар ашиглалтад төрийн хяналтыг хэрэгжүүлэх, хамгаалах, нөхөн сэргээх ажлыг зохион байгуулах;	ДЧҮ-6.1: Газрын төлөв байдал, чанарыг тодорхойлох, үнэлгээ өгөх, чанарын өөрчлөлтийг улсын хэмжээнд хянан дүгнэх үүрэг бүхий хяналт шинжилгээ /мониторинг/-ний сүлжээ ажиллуулах;	
	ДЧҮ-6.2: Газрын доройтлыг бууруулах, нөхөн сэргээх аргачлалыг боловсруулах, хэрэгжүүлэх;	
	ДЧҮ-6.3: Геодези, зураг зүйн улсын хяналтыг хэрэгжүүлэх;	

	ДЧҮ-6.4: Улсын хэмжээнд газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны үйл ажиллагаанд хяналт тавих;	
	ДЧҮ-6.5: Газрыг хамгаалах, нөхөн сэргээх, газар зохион байгуулалтын үйл ажиллагаанд хяналт тавих;	
	ДЧҮ-6.6: Газрын хууль тогтоомж, газар зохион байгуулалт, газрын кадастр, төлөв байдал, чанарын хянан баталгааны үйл ажиллагаанд төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх;	
Ерөнхий чиг үүрэг-2: Байрлалд суурилсан орон зайн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэх, нийтэд үйлчлэх		
ҮЧҮ-7: Байрлалд суурилсан орон зайн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлж, түгээх нэгдсэн систем бий болгох	ДЧҮ-7.1: Байрлалд суурилсан орон зайн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэх, боловсруулах, хадгалах, хамгаалах, түгээх, ашиглах бодлого, хууль эрх зүйн орчин, стандартын тогтолцоог бүрдүүлэх;	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар,
	ДЧҮ-7.2: Байрлалд суурилсан орон зайн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэх;	Орон зайн мэдээллийн технологийн орон тооны бус мэргэжлийн зөвлөл, бусад төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллага
	ДЧҮ-7.3: Байрлалд суурилсан орон зайн өгөгдөл, мэдээлэлд хялбар хандах, хайх боломж бүхий түгээх систем бий болгох;	
ҮЧҮ-8: Салбарын цахим систем, цахим үйлчилгээний хэвийн, аюулгүй, найдвартай үйл ажиллагааг хангах;	ДЧҮ-8.1: Геопортал платформ, Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим систем, геодезийн байрлалын сүлжээний өгөгдлийг боловсруулах цахим систем, гар утасны аппликейшн, цахим үйлчилгээний төхөөрөмжийн хэвийн, аюулгүй, найдвартай үйл ажиллагааг хангах;	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын холбогдох хэлтсүүд, Нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын алба, 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Орон зайн мэдээллийн технологийн орон тооны бус мэргэжлийн зөвлөл, Үндэсний Дата төв
	ДЧҮ-8.2: Өгөгдөл, мэдээлэл, үйлчилгээний шинэлэг, баталгаатай, чанартай, бэлэн байдлыг хангах, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад түгээх, мэдээллийн ил тод байдлыг хангах;	
Ерөнхий чиг үүрэг-3:Салбарын менежмент, хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх		
ҮЧҮ-9: Салбарын нэгдмэл, төвлөрсөн	ДЧҮ-9.1: Төрөөс газрын талаар баримтлах бодлого, шийдвэрт нийцүүлэн салбарын стратеги төлөвлөгөө болон гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, батлах.	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын холбогдох

удирдлагыг хэрэгжүүлэх;	хэрэгжүүлэх;	хэлтсүүд, Нийслэл, дүүргийн газар зохион байгуулалтын алба, 21 аймгийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, газрын даамал
	ДЧҮ-9.2: Харьяа нэгж, албан хаагчдын ажлын уялдааг хангуулах, улсын хэмжээнд нэгдсэн бодлого хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;	
	ДЧҮ-9.3: Салбарын бодлого, хэрэгжилт болон бусад салбарын бодлогын уялдааг хангах, оролцогч талуудад мэргэжлийн зөвлөгөө өгч, хамтран ажиллах;	
ҮЧҮ-10: Салбарын хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тогтвортой ажиллуулах бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх	ДЧҮ-10.1: Хүний нөөцийн бодлогыг тодорхойлох, баталж, хэрэгжүүлэх;	
	ДЧҮ-10.2: Салбарын хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх чиглэлээр их, дээд сургууль, төрийн бус байгууллага, бусад улсын ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагатай хамтран ажиллах;	
ҮЧҮ-11: Салбарын төрийн архивын сан хөмрөгийг бүрдүүлэх, бүртгэх, хадгалах, хамгаалах, ашиглах		

ГУРАВ. АЛСЫН ХАРАА

Хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийг тогтвортой хөгжүүлэхэд орон зайн найдвартай өгөгдөл, мэдээллээр хангагч салбар болно.

ДӨРӨВ. ЭРХЭМ ЗОРИЛГО

Цахим, ил тод, ухаалаг, тогтвортой газрын харилцааны удирдлагын тогтолцоог хөгжүүлж, хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн сэтгэл ханамжаар үнэлэгдэх үйлчилгээг хүргэнэ.

ТАВ. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Стратегийн төлөвлөгөөг боловсруулахын тулд хуулийн хүрээнд тодорхойлогдсон чиг үүргээ хэрэгжүүлэх чадавхын өнөөгийн давуу, сул тал, орчны нөлөөллийн боломж, эрсдэлийг илэрхийлэх гол хүчин зүйлсийг тус тус сонгож авсан.

Стратегийн зорилтыг тодорхойлохдоо дээрх шинжилгээний үр дүнд тулгуурлан давуу талдаа түшиглэн, сул талаа бууруулахад чиглэсэн арга замыг сонгож, гадаад орчны боломжийг ашиглаж, эрсдэлийг бууруулах зарчмыг баримталсан.

Свот шинжилгээний үр дүн

Гадаад орчны шинжилгээ		
	Боломж	Аюул
Улс төр	- Улсын бодлого тодорхойлогдоно. Засгийн газрын болон харьяа байгууллагын бүтэц оновчтой зохион байгуулагдвал эерэг нөлөө үзүүлэх боломжтой. - Хууль тогтоомжийн дагуу тодорхой мандат, эрх мэдэл олгогдсон.	- Төрийн бодлого залгамж чанар алдагдах, тогтвортой бус байдал бий болгох. - Төрийн байгууллагын бүтэц орон тооны өөрчлөлтөөс хамаарч хүний нөөцийн тогтвортой байдал алдагдах. - Хүнд суртлаас шалтгаалан ажил удаашрах. - Улс төрийн тэргүүлэх чиглэл өөрчлөгдсөнөөс шалтгаалж агентлагийн санхүүжилт буурах эрсдэл.
Эдийн засаг	- Улсын төсвөөс санхүүжилтээ авдаг тул үйл ажиллагааны тасралтгүй байдал хангагдсан. - Олон улсын байгууллагын дэмжлэгээр салбарын зарим тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилготой төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлэх боломжтой. - Технологийг шинэчлэхэд төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх.	- Төсөв, хөрөнгийн хүрэлцээгүй байдал. - Хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр зогсонги байдалд орох эрсдэлтэй. - Дэвшилтэт технологи, чадварлаг ажиллах хүчний зардал нэмэгдэх хандлага. - Судалгаа, инноваци, олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх нөөц хязгаарлагдмал.
Нийгэм соёл	- Газрын харилцааны чиглэлээр олон нийтэд нөлөөлөх түвшин өндөр. - Монгол Улсын орон зайн өгөгдлийн гол байгууллага гэдгээр иргэдийн итгэлийг хүлээсэн.	- Агентлагийн үүрэг, хийсэн ажлын хувь нэмрийн талаарх олон нийтийн мэдлэг хязгаарлагдмал. - Олон нийт худал мэдээлэлд автах, засгийн газрын тэргүүлсэн төслүүдэд итгэхгүй байх.
Технологи	- Монгол улсын урт хугацааны бодлого Алсын хараа 2050–ын хүрээнд Цахим засаглал хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. - Мэдээллийн болон технологийн нөөцийн хувьд тодорхой хэмжээгээр бэхэжсэн. - Хурал, хэлэлцүүлэг, сургалт зэрэг арга хэмжээг цахимаар зохион байгуулснаар цаг хугацаа, зардал хэмнэгддэг.	- Нөөцийн сервер, тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангах, тоног төхөөрөмжийг шинэчлэх шаардлагатай. - Архив, бичиг баримтын мэдээллийн аюулгүй байдлыг сайжруулах шаардлагатай. - Том өгөгдлийн аналитик болон хиймэл оюун ухааныг нэгтгэх хүчин чадал хязгаарлагдмал. - Орон зайн мэдээллийн сангийн шинэчлэлт удаашралтай.

Хууль эрх зүй	- Хууль эрх зүйн тодорхой хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг. - Хууль эрх зүйн орчин боловсронгуй болсоор байгаа. - Газрын тухай хууль, холбогдох журмуудад нэмэлт өөрчлөлт орох, шинээр журмууд батлагдсан.	- Багц хуулийн төслүүд батлагдаагүй удаж байгаа бөгөөд хэзээ батлагдах нь тодорхойгүй. - Үндэсний Орон зайн өгөгдлийн дэд бүтцийг байгуулах үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн орчин хангалттай бүрдээгүй.
Байгаль орчин	- Дэлхий дахинд илүү сайн хүлээн зөвшөөрөгдөхийн тулд олон улсын байгаль орчны зорилтуудтай нийцэн ажиллах. - Өгөгдөлд суурилсан бодлогоор дамжуулан уур амьсгалын өөрчлөлтийг бууруулахад оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх.	- Газрын менежментэд нөлөөлж буй байгалийн гамшгийн давамж нэмэгдсэн. - Уур амьсгалын өөрчлөлт нь газрын доройтол, нөөцийн хомсдолд хүргэж байна.
Дотоод орчны шинжилгээ		
	Давуу	Сул
Байгууллагын бүтэц	- Засгийн газрын тогтоол, Улсын Их Хурлын 2023 оны 21 дүгээр тогтоол, 2023 оны 454 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 14 дүгээр захирамжаар холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулж Агентлагийн бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, нэгжүүдийн үйл ажиллагааны уялдаа холбоог үйл ажиллагааны онцлог, чиглэлд нийцүүлэн шинэчилсэн. - Нийслэл, 21 аймагт харьяа нэгж бүхий тогтолцоо төлөвшиж, тасралтгүй үйл ажиллагааг явуулдаг; - Албан тушаалын тодорхойлолт батлагдсан; - Байгууллага хамт олны уур амьсгал, хоорондын харилцаа холбоо сайн, ажлын хариуцлагатай;	- Агентлагийн үндсэн бүтцийн нэгж, агентлаг, холбогдох харьяа байгууллагууд хоорондын ажлын уялдаа холбоо сул. - Албан тушаалын тодорхойлолт батлагдсан боловч ажлын гүйцэтгэлд тодорхой тусгагдаагүй. Боловсон хүчний шилжилт хөдөлгөөн их, хүний нөөцийн бодлого дээр анхаарах шаардлагатай;
Дотоод үйл ажиллагааны хяналт	- Байгууллагын дотоод журмыг 2024 оны 05 сарын 07 дугаар сарын А/147 дугаар тушаалаар баталсан, журмын дагуу үйл ажиллагаа явагддаг. - Байгууллагын соёл ажилтан, албан хаагч нарт тогтсон. - Албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журмын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийдэг. - Ажилтныг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд тогтмол хамруулдаг. - Шинэ залуу боловсон хүчнийг бэлтгэхэд анхаарч ажиллах нь нэмэгдсэн;	- Салбарын бодлого, чиглэлийг боловсруулах мэргэжлийн баг бүрдүүлэх боломж, санхүүгийн нөөц, орон тоо дутагдалтай. - Байгууллагын соёлын хүрээнд хамт олны уур амьсгал, ажлын байр, нийгмийн баталгааг нэмэгдүүлэх, сайжруулах шаардлагатай; - Сурч боловсрох, мэдлэг ур чадвараа дээшлүүлэхэд ажлын ачаалал сөргөөр нөлөөлдөг;

Хүний нөөц, түүний чадамж	- Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” https://hrs.gov.mn/auth/login/ цахим системд албан хаагчдын мэдээллийг оруулсан. - Удирдлагын академийн 2024 оны сургалт, судалгааны ажлын төлөвлөгөөний дагуу зохион байгуулагдаж буй сургалтад холбогдох албан хаагчдыг тогтмол хамруулдаг. - Салбарын мэргэжилтнийг давтан сургах, мэргэшлийн зэрэг олгох, сунгах дүрмийг ГЗБГЗЗЕГ-ын 2024 оны 08 сарын 06-ний А/239 тушаалаар баталсан. - Төрийн албаны тухай хууль тогтоомжид заасны дагуу мэдлэг мэргэшлийг дээшлүүлэх сургалтад үе шаттайгаар хамрагддаг.	- Сургалтын асуудлыг шийдэхэд дэмжлэг, туслалцаа үзүүлэх төсөв, хөрөнгийн боломж дутмаг. - Анх ажилд томилогдсон албан хаагчдад чиглүүлэх сургалт явуулдаггүй. - Төрийн албаны тухай хуулийн дагуу албан тушаалын шатлан дэвших зарчмын хэрэгжилт хангалтгүй. - Орон нутагт хүний нөөц муу
Ажлын байрны орчин нөхцөл	- Ажиллах орчин, тоног төхөөрөмжөөр хангагдсан. - Урагшаа харсан цонхтой өрөө тасалгаа байгалийн гэрэл сайн үздэг. - Хэд хэдэн өрөөнд засвар хийсэн. - Төрийн тусгай хамгаалалтад байдаг. - Ариун цэврийн өрөөг засварласан.	- Байгууллагын байрлаж буй байр хуучирсан, мөөгөнцөр болон элдэв бохир үнэртдэг. - Бүрэн тохижилттой цайны өрөө, хувийн уулзалтын өрөө байхгүй. - Байгууллагын авто машины зогсоолгүй. - Эмч болон эрүүл мэндийн өрөө тасалгаа байхгүй. - Анхан шатны тусламж үзүүлэх эм хэрэгсэл байдаггүй
Санхүүгийн нөөц	- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжилт шийдэгддэг. - Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн дэмжлэгээр нэмэлт санхүүжилт, болон холбогдох ажлуудын зардлууд шийдэгддэг. - Нийгмийн баталгааг хангаж ажилладаг;	- Байгууллагын дотоод орлого байхгүй. - Улсын төсөв гэнэтийн асуудал, шуурхай ажлын зардлыг шийдвэрлэхэд хангалттай бус. - Илүү цагийн хөлс боддоггүй;

ЗУРГАА. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО

- Орон зайн дүн шинжилгээ, нотолгоонд суурилсан газар зохион байгуулалтын төлөвлөлтөөр дамжуулж газрын нөөцийг оновчтой хуваарилах замаар уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, тогтвортой газар ашиглалтыг бий болгох;
- Монгол Улсыг зурагжуулах, геодезийн сүлжээний нарийвчлалыг сайжруулах;
- Геодези, зураг зүйн салбарын хууль, эрх зүйн орчныг сайжруулах;
- Төрөөс үзүүлж буй геодези, зураг зүйн үйлчилгээг цахимжуулах, хэрэглэгчдэд нээлттэй болгох;

- Олон улсын гэрээ хэлэлцээр хэрэгжүүлэх;
- Хиймэл оюун ухаан, блокчейн технологийг ашиглан газар, үл хөдлөх хөрөнгийн хаягийн нэгдсэн системийг байгуулж, хэрэглээнд нэвтрүүлэх;
- Газрын кадастрын нэгдсэн системийн үйл ажиллагааг боловсронгуй болгож цахимаар үзүүлэх төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх;
- Хиймэл оюун ухаан, блокчейн болон газар зүйн мэдээллийн системд суурилсан гурав, дөрвөн хэмжээст кадастрын мэдээллийн нэгдсэн системийг бий болгож хөгжүүлэх;
- Газрын биржийн үйл ажиллагааг зохих журмын дагуу удирдан зохион байгуулах, боловсронгуй болгох;
- Газар, үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ, үнэ цэнийг нэмэгдүүлэх, төлбөр, татварыг оновчтой тогтоох, боловсронгуй болгох нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх;
- Газар, үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ, үнэ цэнийг нэмэгдүүлэх газрын суурь үнэлгээг шинэчлэн тогтоох;
- Хяналт шалгалтын эрх зүйн орчныг сайжруулж, төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх;
- Хяналт шалгалтын нэгдсэн тогтолцоог бий болгож, хариуцлагатай газрын харилцааг бэхжүүлэх;
- Зайнаас тандан судлалын арга зүйг нэвтрүүлсэн газар ашиглалт, газрын мониторингийн байнгын ажиллагаатай хяналтын системийг хөгжүүлж, газрын доройтол, бохирдлыг шинжлэх ухааны үндэслэлтэй судлан тогтоож, нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэх, нэгдсэн мэдээллийн сан байгуулах;
- Салбарын хууль тогтоомжийн төслийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлал, хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлэх хуулийн төслийг боловсруулж, батлуулах, холбогдох байнгын хороо болон Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлэх;
- Орон зайн өгөгдлийн дэд бүтцийг байгуулах, үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;
- Салбарын өгөгдөл, мэдээлэл, түүнийг хадгалах, боловсруулах, дамжуулах техник, тоног төхөөрөмж, программ хангамжийн аюулгүй, хэвийн, найдвартай үйл ажиллагааг хангах;
- Төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлж манлайлан ажиллах;
- Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн салбарын хөгжил, бодлогын үр нөлөөг дээшлүүлж, судалгаа, төлөвлөлтийн чанарыг сайжруулах;
- Төрийн архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулах;
- Төрийн албан хаагчдыг нийтлэг үүргээ хэрэгжүүлэх нөхцөлөөр хангах, сайжруулах.

ДОЛОО. СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫГ ХЭМЖИХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, СУУРЬ БОЛОН ЗОРИЛТОТ ТҮВШИН, СТРАТЕГИ

Бодлогын баримт бичигт тусгагдсан, болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт	Стратеги /арга зам/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Санхүүгийн эх үүсвэр
Ерөнхий чиг үүргийн нэр: Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн салбарын бодлогыг хэрэгжүүлэх					
Үндсэн чиг үүргийн нэр: Газар зохион байгуулалтын бодлогыг хэрэгжүүлэх					
Стратегийн зорилго: Орон зайн дүн шинжилгээ, нотолгоонд суурилсан газар зохион байгуулалтын төлөвлөлтөөр дамжуулж газрын нөөцийг оновчтой хувиарлах замаар уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, тогтвортой газар ашиглалтыг бий болгох					
Зорилт-1. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн, тогтвортой газар ашиглалтад чиглэсэн нутаг дэвсгэрийн газар зохион байгуулалтын төлөвлөлтийг боловсруулж, хэрэгжүүлэх	Арга хэмжээ-1 Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулна.	Батлагдсан улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө	Засгийн газрын 2018 оны 384 дүгээр тогтоолоор батлагдсан.	Төлөвлөгөөний төслийг боловсруулах, Улсын хэмжээнд 21 аймаг, нийслэлээс төслийг хэлэлцүүлэг зохион байгуулж, төслийг 3Г-т өргөн барьж батлуулсан байна.	Улсын төсөв (1200 сая)
	Арга хэмжээ-2 Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах	Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөгөө шинэчилсэн болон нэмэлт тодотгол хийсэн аймгийн тоо	Нийслэл болон 19 аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулагдсан.	Хөвсгөл, Ховд, Өвөрхангай, Увс аймгуудын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, Дархан-Уул, Говьсүмбэр, Дорноговь аймгуудын төлөвлөгөөнд тодотгол хийсэн байна.	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр
	Арга хэмжээ-3 Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах	Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулсан сумдын тоо	198 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө хийгдсэн	132 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулсан байна.	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр

	Арга хэмжээ-4 Газар зохион байгуулалт, төлөвлөлтийн арга зүйн баримт бичгийг боловсронгуй болгох	Боловсруулсан аргачлал	Аймаг, сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах аргачлал батлагдсан	"Нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөний аргачлал", "Газар ашиглалтын тохиромжтой байдал, хэрэгцээт байдлын үнэлгээний аргачлал"-ыг боловсруулж, батлуулсан байна.	Урсгал зардал
Зорилт-2. Бүсчилсэн хөгжлийг дэмжиж, төвлөрлийг сааруулах Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийн оновчтой хуваарийг тогтоох	Арга хэмжээ-1 Хот байгуулалтын тухай, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай, Газрын тухай хууль, тогтоомж холбогдох норм, дүрэмд нийцүүлэн хотын эдэлбэр газрыг тогтоох ажлыг зохион байгуулах	Эдэлбэр газрыг тогтоосон хот, тосгон бусад суурин газрын тоо	Нийслэл Улаанбаатар хотын эдэлбэр газрыг тогтоосон	21 аймаг, 330 сум, 12 хилийн боомтын эдэлбэр газрыг тогтоосон байна.	Улсын төсөв
	Арга хэмжээ-2 Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийн эргэлтийн цэгүүдийг геодезийн солбицлоор тогтоон, баталгаажуулах ажлыг үе шаттай зохион байгуулах	21 аймаг, 330 сум, Нийслэл, 9 дүүрэг	Улсын хэмжээнд хилийн цэсийн 13444 эргэлтийн цэгийн солбицлыг тогтоосон	Хилийн цэсийн эргэлтийн цэгүүдийн солбицлыг засаг захиргааны нэгж тус бүрээр боловсруулж ЗГХЭГ-т хүргүүлсэн байна.	Улсын төсөв
	Арга хэмжээ-3 Аймгийн төвтэй ойр сумдын судалгааг хийж, эдэлбэр газрыг тогтоож, засаг захиргаа, нутаг	21 аймаг, 330 сум, Нийслэл, 9 дүүрэг	Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлагдсан	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийг оновчтой хуваарилан, саналыг Засгийн газарт танилцуулсан байна.	Улсын төсөв

	дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийг тодотгох ажлыг зохион байгуулах				
Зорилт-3. Орон зайн дүн шинжилгээнд суурилсан газар зохион байгуулалтын төлөвлөлт, шийдвэр гаргалтыг дэмжих ухаалаг цахим системийг бий болгож, хэрэглээнд нэвтрүүлэх	Арга хэмжээ-1 “Газрын тохиромжтой болон хэрэгцээт байдлын үнэлгээ, газар зохион байгуулалтын төлөвлөлт, хяналтын систем”-ийн хөгжлүүлэлтийг хийх	Систем хөгжүүлэлтийн түвшин	2021 онд ТЭЗҮ боловсруулж, батлуулсан.	Систем хангамжийг хэрэглээнд нэвтрүүлсэн байна.	Улсын төсөв
	Арга хэмжээ-2 Хуулиар тогтоосон хориглолт, хязгаарлалт хамгаалалтын бүс, зурвас газрын нэгдсэн мэдээллийн санг Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем түшиглэн байгуулах.	Мэдээллийн санд орсон 21 аймгийн 330 сумын усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүс, Нийслэлийн ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүс, тэжээгдлийн мужийн хил зааг	Монгол Улсын Засгийн Газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 50 дугаар хурлын тэмдэглэлд дурдсан Авто замын мэдээллийг цахим системд оруулсан.	Нийслэлийн ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүс, тэжээгдлийн мужийн заагийг байгаль орчны болон газрын харилцааны асуудал эрхэлсэн байгууллагатай хамтран тогтоох ажлыг зохион байгуулах. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамдын сав газартай хамтран усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүсийн мэдээллийг авч цахим системд оруулсан байна.	Улсын төсөв
	Арга хэмжээ-3 Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах үйл ажиллагааг цахимжуулж хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах.	Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах үйл ажиллагааг цахимжуулж хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах Модулийн хөгжүүлэлтийн түвшин	Улсын тусгай хэрэгцээнд нийт 998 газрыг авсан байна.	Газрын удирдлагын нэгдсэн цахим системийн хөгжүүлэлт, хэвийн үйл ажиллагааг хангах ажлыг зохион байгуулах, Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах үйл ажиллагааг цахимжуулах ажлын даалгаврыг боловсруулж, батлуулах, Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах үйл	Улсын төсөв, төсөл хөтөлбөр

				ажиллагааг цахимжуулах модулийг хэрэглээнд нэвтрүүлсэн байна.	
Үндсэн чиг үүргийн нэр: Геодези, зураг зүйн бодлогыг хэрэгжүүлэх					
Стратегийн зорилго 1: Монгол Улсыг зурагжуулах, геодезийн сүлжээний нарийвчлалыг сайжруулах					
Зорилт-1. Монгол Улсын геодезийн байрлал, өндөр, гравиметрийн сүлжээний нарийвчлалыг сайжруулах	Арга хэмжээ-1 Монгол Улсын өндрийн тулгуур сүлжээг шинэчилж өндрийн сүлжээний нарийвчлалыг сайжруулах	Өндрийн 2-р ангийн сүлжээ	2014-2023 онд өндрийн 1-р ангийн сүлжээг шинээр байгуулсан. "Монгол Улсын өндрийн тулгуур сүлжээг шинэчлэх" ТЭЗҮ-г 2023 онд шинэчилж батлуулсан.	Монгол Улсын өндрийн II ангийн сүлжээний давтан хэмжилт, тэгшитгэн бодолт хийгдэж, өндрийн тулгуур сүлжээний нэгдсэн мэдээллийн сан үүсгэсэн байна.	Улсын төсөв 22,902 сая төгрөг
	Арга хэмжээ-2 Монгол Улсын гравиметрийн сүлжээг шинэчлэн сайжруулах	Гравиметрийн сүлжээний 1, 2-р ангийн сүлжээний 134 цэг	"Монгол Улсын гравиметрийн сүлжээг шинэчлэн сайжруулах" Техник эдийн засгийн үндэслэлийг 2023 онд шинэчилж батлуулсан.	Монгол Улсын гравиметрийн сүлжээний давтан хэмжилт, тэгшитгэн бодолт хийж, гравиметрийн сүлжээний нэгдсэн мэдээллийн сан үүсгэсэн байна.	Улсын төсөв 13,625.9 сая төгрөг
	Арга хэмжээ-3 GNSS-ийн байнгын ажиллагаатай суурин станцын сүлжээг өтгөрүүлэх, техник хангамж болон програм хангамжийн шинэчлэлтийг хийж нэгдсэн удирдлагын системд холбох	GNSS-ийн байнгын ажиллагаатай 15 станц, нэгдсэн удирдлагын систем	2000-2024 онд Улсын хэмжээнд 48 станц суурилуулсан. "GNSS-ийн байнгын ажиллагаатай станцын сүлжээг өтгөрүүлэх" ТЭЗҮ-г шинэчлэн боловсруулж ГЗБГЗЕГ-ын даргаар 2023 онд батлуулсан.	Байнгын ажиллагаатай суурин станц байгуулсан сум суурин газарт геодезийн хэмжил зураглалын ажлын нарийвчлал сайжирч тоон мэдээллийг хэрэглэгчдэд түгээх цахим тогтолцоог бий болгоно.	Улсын төсөв хөрөнгө 2,500 сая төгрөг
	Арга хэмжээ-4 GNSS-ийн байнгын ажиллагаатай суурин станцын хэвийн үйл ажиллагааг хангах	48 станц	2013-2024 онд Улсын төсвөөр 43, нийслэлийн төсвөөр УБ хотод 5 станц суурилуулсан. 2024 онд GNSS-ийн байнгын ажиллагаатай	GNSS-ийн байнгын ажиллагаатай 48 станцын тасралтгүй хэвийн ажиллагааг хангах ажлыг зохион байгуулна.	Үйл ажиллагаа

			48 станцын нэгдсэн удирдлагын тогтолцоо бүрдүүлсэн.		
Арга хэмжээ-5 GNSS-ийн байнгын ажиллагаатай суурин станц шинээр байгуулах	2 станц		2024 онд GNSS-ийн байнгын ажиллагаатай 5 станц шинээр байгуулсан.	Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан, Ховд аймгийн Булган сумдад байнгын ажиллагаатай суурин станц байгуулж тухайн суманд хийгдэх байрзүйн зураглалын сүлжээний ажилд навигацийн хиймэл дагуулын бодит агшны засвар дамжуулалтыг ашиглах боломж бүрдэнэ.	2025 оны улсын төсөв 220 сая төгрөг
Арга хэмжээ-6 Геодезийн байрлал, өндөр, гравиметр, GNSS-ийн сүлжээний ITRF2008 солбицлын тогтолцоонд тодорхойлсон цэг тэмдэгтийг ITRF2020 солбицлын тогтолцоонд шилжүүлэх	Тоо хэмжээг архиваас тодруулах		Хийгдсэн ажлын тайланг Архивын хэлтсээс харах	Геодезийн байрлал, өндөр, гравиметр, GNSS-ийн сүлжээний ITRF2008 солбицлын тогтолцоонд тодорхойлсон цэг тэмдэгтийг ITRF2020 солбицлын тогтолцоонд шилжүүлэх ажлыг зохион байгуулна.	Үйл ажиллагаа
Арга хэмжээ-6 Геодезийн цэг тэмдэгтийн мэдээллийн санг хөтлөх	Улсын хэмжээнд нийт 22000 орчим цэг тэмдэгт		Геодезийн цэг, тэмдэгтийн мэдээллийн санг шинэчилж, 2022 онд мэдээллийн санг цахимаар түгээх тогтолцоог бүрдүүлсэн.	Бусад байгууллагын захиалгаар хийгдсэн геодезийн ажлын цэг, тэмдэгтийн мэдээллээр геодезийн цахим сангийн шинэчлэлтийг хөтөлнө.	Үйл ажиллагаа
Арга хэмжээ-7 Геодезийн байнгын цэг, тэмдэгтийг хадгалах, хамгаалах, тооллого хийх, нөхөн сэргээх ажлыг зохион байгуулах	Монгол Улсын нийт нутаг дэвсгэрт байршуулсан 21000 орчим геодезийн цэг, тэмдэгт		Геодезийн цэг, тэмдэгтийн мэдээллийн санг шинэчилж, 2022 онд мэдээллийн санг цахимаар түгээх тогтолцоог бүрдүүлсэн.	Геодезийн цэг тэмдэгтийн цахим системийн шинэчлэлтэд хяналт тавьж, 21 аймагас ирүүлсэн хүсэлтийг баталгаажуулна.	Үйл ажиллагаа
Арга хэмжээ-8	Улаанбаатар хот,		УБ хотын солбицлын	21 аймаг 330 сумын геодезийн	Үйл ажиллагаа

	Солбицлын дэд тогтолцоог байгуулах	330 сум, суурингийн солбицлын дэд тогтолцоо, хөрвүүлэлтийн утга	дэд тогтолцоог Газрын даргын 2024 оны А/331 дугаар тушаалаар баталсан.	дэд тогтолцоог байгуулан, параметрын хөрвүүлэлтийн утгыг гаргаж баталсан байна.	
Зорилт-2. Монгол Улсын нутаг дэвсгэрийг төрөл бүрийн масштабтай газрын зургаар зурагжуулах, газар зүйн нэрийг тодруулах	Арга хэмжээ-1 1:1000-ны масштабтай тоон дэвсгэр зургийг шинээр гүйцэтгэх.	1:1000-ны масштабтай тоон дэвсгэр зураг	Нийслэл, Өмнөговь аймгийн төв, 4 сумын төвийг ITRF2020 тогтолцоонд 1:1000-ны масштабтай тоон байр зүйн зургийг 2024 онд шинээр гүйцэтгэж байна.	ITRF2020 тогтолцоонд 21 аймгийн 330 сум, 45 суурин, нийслэлийн нутаг дэвсгэрт 1:1000-ны масштабтай тоон байр зүйн зургийг шинээр гүйцэтгэсэн байна.	Улсын төсөв хөрөнгө 37 тэрбум төгрөг
	Арга хэмжээ-2 Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийг 1:25000 масштабтай байр зүйн зургаар зурагжуулах	Монгол Улсын нутаг дэвсгэрийн 55% хувийг зурагжуулах, 913872.4 км2 нутаг дэвсгэрийн 10914 хуудас 1:25000-ны масштабтай байр зүйн тоон зураг.	2020 онд Монгол Улсын нутаг дэвсгэрийн 45%-ийг 1:25000-ны масштабтай байр зүйн зургаар зурагжуулж, 7328 хуудас зураг хийгдсэн.	Хэрэглэгчдэд шуурхай хүргэж, хэрэглэгчдийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн байр зүйн болон баталгаажсан нэг маягийн суурьтай сэдэвчилсэн газрын зураг, атласаар хангана.	Улсын төсөв- 97,538.5 сая төгрөг
	Арга хэмжээ-3 Газар зүйн нэрийн тодруулалт, мэдээллийн сан бүрдүүлэх	Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд хамаарах 350 мянган газар зүйн нэр	2019-2024 онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр 16 аймгийн 117 сум, нийслэлийн 5 дүүргийн газар зүйн нэрийн тодруулалт, мэдээллийн сан бүрдүүлэх ажил хийгдсэн.	Газар зүйн нэрийг тодруулан тогтоож Улсын Их Хурлаар батлуулж, хаягжуулалтад ашигласан байна.	Улсын төсөв- 14,624.3 сая төгрөг
	Арга хэмжээ-4 Газарзүйн нэрийг полигонжуулах, арга аргачлал боловсруулах	Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрт хамаарах 8995 газар зүйн нэр	2021-2022 онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр Сүхбаатар аймгийн 13 сумын газар зүйн нэрийн тодруулалт, мэдээллийн сан бүрдүүлэх ажил хийгдсэн.	Газар зүйн нэр бүрийн хамрах хүрээг тогтоох арга аргачлалыг боловсруулж Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрт хамаарах бүх газар зүйн нэрийг суурин байдлаар хамрах хүрээг тогтоож, хаягжуулалтад ашигласан байна.	Урсгал төсөв 100 сая төгрөг

	Арга хэмжээ-5 Хэвлэлийн тоног төхөөрөмж худалдан авах	1 хэвлэлийн машин	Монгол Улс, ОХУ хоорондын улсын хилийг шалгаж, зураглах ажил 2023 оноос эхлүүлсэн.	Хэвлэлийн тоног төхөөрөмжтэй болсон байна.	Улсын төсөв 3200 сая төгрөг
	Арга хэмжээ-6 Газар зүйн нэрийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж иргэд олон нийтэд үйлчилгээ үзүүлэх	214805 нэрийн мэдээллийн санг шалгаж засварласан.	15 аймгийн 114 сум, нийслэлийн 5 дүүргийн газар зүйн нэрийн тодруулалт, мэдээллийн санг нэгтгэсэн.	Газар зүйн нэрийн нэгдсэн мэдээллийн сан, систем үүсгэж иргэд, олон нийтийг үнэн зөв, түүхэн, уламжлалт газар зүйн нэрийн мэдээллээр хангасан байна.	Үйл ажиллагаа
Стратегийн зорилго 2: Геодези, зураг зүйн салбарын хууль, эрх зүйн орчныг сайжруулах					
Зорилт 1. Геодези, зураг зүйн тухай хуулийг шинэчлэн батлуулах	Арга хэмжээ-1 Геодези, зураг зүйн тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулж батлуулах	Геодези, зураг зүйн хуулийн төслийн үзэл баримтлал	Геодези зураг зүйн тухай хуулийн үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулсан.	Геодези, зураг зүйн тухай хуулийн үзэл баримтлалыг батлуулсан байна.	Үйл ажиллагаа
	Арга хэмжээ-2 Геодези, зураг зүйн тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төслийг олон нийтээр хэлэлцүүлэх	Зохион байгуулах хэлэлцүүлэг	Геодези зураг зүйн тухай хуулийн үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулсан.	21 аймаг, нийслэлд хуулийн төслийг хэлэлцүүлсэн байна.	Урсгал төсөв
	Арга хэмжээ-3 Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг батлуулахад хамтран ажиллах	Өргөн барьсан 1 хуулийн төсөл	Геодези зураг зүйн тухай хуулийн үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулсан.	Геодези, зураг зүйн тухай хуулийг шинэчлэн батлуулсан байна.	Үйл ажиллагаа
Зорилт 2. Геодези, зураг зүйн дүрэм, журам, батлуулах, Техник,	Арга хэмжээ-1 Геодезийн хэмжих хэрэгсэл шалгах, баталгаажуулах үйл	Техник, эдийн засгийн үндэслэл	2024 онд техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах Ажлын даалгаврыг боловсруулж	“Геодезийн хэмжих хэрэгсэл шалгах, баталгаажуулах үйл ажиллагааг өргөжүүлэх” ТЭЗҮ-ийг батлуулсан байна.	Үйл ажиллагаа

эдийн засгийн үндэслэл боловсруулах	ажиллагааг өргөжүүлэх ТЭЗҮ.		батлуулсан.		
	Арга хэмжээ-2 “Хот, тосгон, бусад суурин газрыг 1:1000-ны масштабтай байр зүйн зургийг олон улсын геодезийн солбицлын тогтолцоонд шилжүүлэх” ТЭЗҮ.	Техник, эдийн засгийн үндэслэл	2024 онд техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах Ажлын даалгаврыг боловсруулж батлуулсан.	“Хот, тосгон, бусад суурин газрыг 1:1000-ны масштабтай байр зүйн зургийг олон улсын геодезийн солбицлын тогтолцоонд шилжүүлэх” ТЭЗҮ-ийг боловсруулж батлуулсан байна.	Үйл ажиллагаа
	Арга хэмжээ-3 “Монгол Улсын гравиметрийн сүлжээг шинэчлэн сайжруулах” ТЭЗҮ-г абсолют гравиметрийн хэмжилтийн үр дүнтэй уялдуулан судалгаа хийх, төсвийн тооцоог шинэчлэн гаргаж Техник, эдийн засгийн үндэслэл боловсруулж батлуулах.	Техник, эдийн засгийн үндэслэл	“Монгол Улсын гравиметрийн сүлжээг шинэчлэн сайжруулах” Техник эдийн засгийн үндэслэлийг 2023 онд шинэчилж БХБЯ-аар батлуулсан. Абсолют гравиметрийн хэмжилтийг 2024 онд хийсэн.	“Монгол Улсын гравиметрийн сүлжээг шинэчлэн сайжруулах” ТЭЗҮ-г шинэчлэн боловсруулж батлуулсан байна.	Үйл ажиллагаа
	Арга хэмжээ-4 “VLBI станц байгуулах” техник, эдийн засгийн үндэслэл боловсруулж батлуулах.	Техник, эдийн засгийн үндэслэл	2023 онд ТЭЗҮ боловсруулах Ажлын даалгавар боловсруулж батлуулсан. Шинжлэх ухаан технологийн сангийн хөрөнгөөр боловсруулах саналыг БХБЯ-нд хүргүүлж ШУТТЗ-өөр хэлэлцүүлсэн боловч дэмжигдээгүй.	“VLBI станц байгуулах” ТЭЗҮ-г боловсруулж батлуулсан байна.	Улсын төсөв 350 сая төгрөг
	Арга хэмжээ-5	Дүрэм	2023 онд техник, эдийн засгийн үндэслэл	“Солбицлын бие даасан тогтолцоог тогтоох, улсын	Урсгал төсөв 20 сая

	“Солбицлын бие даасан тогтолцоог тогтоох, улсын солбицлын тогтолцоонд шилжүүлэх хөрвүүлгийн утгыг тодорхойлох” дүрэм		боловсруулах Ажлын даалгавар боловсруулж батлуулсан.	солбицлын тогтолцоонд шилжүүлэх хөрвүүлгийн утгыг тодорхойлох” дүрмийг батлуулсан байна.	
	Арга хэмжээ-6 “Газар зүйн нэрийг тодотгох, тогтоох, солбицолжуулах, баталгаажуулах, газар зүйн нэрийн зураг зохиох” журам	Журам	2022 онд журмын төслийг боловсруулан 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн геодези, зураг зүйн ОТБМЗХ-аар хэлэлцүүлсэн. ДДЗХ-ын 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн хурлаар хэлэлцүүлсэн.	“Газар зүйн нэрийг тодотгох, тогтоох, солбицолжуулах, баталгаажуулах, газар зүйн нэрийн зураг зохиох” журмыг шинэчлэн боловсруулж холбогдох хурлаар хэлэлцүүлэн ЗГ-аар батлуулсан байна.	Үйл ажиллагаа
	Арга хэмжээ-7 “Хот суурин газрын өндөржилт төлөвлөлт хийх геодезийн ажил” барилгын дүрэм батлуулах	Барилгын дүрэм	Дүрмийн төслийг 2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн Геодези, зураг зүйн орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн хурлаар дүрмийн төслийг хэлэлцүүлж дэмжигдсэн.	Барилгын дүрмийг боловсруулж батлуулсан байна.	
	Арга хэмжээ-8 “Усны ёроолын геодезийн хэмжил, зураглалын ажил” БД батлуулах	Барилгын дүрэм	Монгол улсын зөвлөх инженер Ч.Цэрэнбат 2024 оны 09 дүгээр сарын 17-ний өдрийн 1/2466 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Барилгын хөгжлийн төвөөс 2024 оны 12 дугаар сарын 20 өдрийн 1/3847 албан бичгээр Геодези, зураг зүйн орон тооны бус	Барилгын дүрмийг боловсруулж батлуулсан байна.	

			мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх хүсэлт ирсэн.		
	Арга хэмжээ-9 Геодезийн хэмжил зүйн лабораторийн үйл ажиллагаанд мөрдөх журмуудад нэмэлт өөрчлөлт оруулж, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний актад бүртгүүлэх	13 журам	2009-2022 онд 13 журмыг боловсруулж батлуулсан.	Журмаар лабораторийн үйл ажиллагааг цахимжуулахтай холбогдсон харилцааг зохицуулан шинэчлэн боловсруулж батлуулсан байна.	Үйл ажиллагаа
Стратегийн зорилго 3: Төрөөс үзүүлж буй геодези, зураг зүйн үйлчилгээг цахимжуулах, хэрэглэгчдэд нээлттэй болгох					
Зорилт-1. Геодезийн хэмжих хэрэгслийг шалгах, баталгаажуулах	Арга хэмжээ-1 Геодезийн хэмжих хэрэгслийг шалгах, баталгаажуулах	Улсын хэмжээнд ашиглаж буй бүх төрлийн геодезийн хэмжих хэрэгсэл	2024 онд геодезийн 2130 хэмжих хэрэгслийг шалгаж, баталгаажуулсан.	Жил бүр геодезийн 2100-аас доошгүй тооны хэмжих хэрэгслийг олон улсын түвшинд нийцүүлэн, дэвшилтэт техник, технологи ашиглан шалгаж, баталгаажуулсан байна.	Үйл ажиллагаа
	Арга хэмжээ-2 Геодезийн хэмжих хэрэгслийг шалгах, баталгаажуулахад шаардлагатай эталон багаж, тоног төхөөрөмжийг шинэчлэх, үйлдвэрлэлд нэвтрүүлэх	Колиматор, тоон нивелир	2000 онд коллиматор багажийг суурилуулсан. 2010 онд автомат нивелир худалдан авсан.	Эталон болгон ашиглаж буй багаж, тоног төхөөрөмжийн нарийвчлал үйлдвэрлэлд ашиглаж буй багаж, тоног төхөөрөмжийн нарийвчлалаас сайжирсан байна.	Улсын төсөв 265 сая төгрөг
	Арга хэмжээ-3 Дунд болон техникийн нарийвчлалтай геодезийн хэмжих хэрэгсэл шалгаж, баталгаажуулах полигон байгуулах	Дунд болон техникийн нарийвчлалтай геодезийн хэмжих хэрэгсэл шалгаж, баталгаажуулах полигон	2009 онд Төв аймгийн Номтын аманд өндөр нарийвчлалтай геодезийн хэмжих хэрэгсэл шалгаж, баталгаажуулах "Жишилтийн полигон"-ыг байгуулсан.	УБ хотоос 100 км-т орших өндөр нарийвчлалын багаж шалгах полигон руу явах шаардлагагүй, хот дотор шалгалтын хэмжилт хийх боломж бүрдэнэ.	Улсын төсөв- 30 сая төгрөг

			Полигоны байгууламжийн зураг, төсвийг хийсэн.		
	Арга хэмжээ-4 Монгол Улсад шинээр импортлогдож буй геодезийн хэмжих хэрэгслийн нарийвчлал, загварыг турших, баталгаажуулах, бүртгэх	Монгол Улсад шинээр импортлогдож буй геодезийн бүх төрлийн хэмжих хэрэгсэл	Үйлдвэрлэлд ашиглагдаж буй геодезийн хэмжих хэрэгслийн нарийвчлалыг шалгадаггүй, туршдаггүй, бүртгэл байдаггүй.	Бүх төрлийн геодезийн хэмжих хэрэгслийн загварыг туршиж, үр дүнг баталгаажуулан бүртгэлжүүлнэ.	Үйл ажиллагаа
	Арга хэмжээ-5 Геодезийн хэмжлийн багаж баталгаажуулах тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, шинэчлэх	тоног төхөөрөмж	Тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангаж ажиллахад урсгал засвар, солих шаардлагтай сэлбэг худалдан авсан.	Лабораторийн үйл ажиллагааг хэвийн явуулах шаардлагыг хангасан байна.	Улсын төсөв
	Арга хэмжээ-6 Геодезийн хэмжлийн багаж баталгаажуулах лабораторийн итгэмжлэл авах	Итгэмжлэл	2024 онд давтан итгэмжлүүлэх хүсэлт хүргүүлсэн. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн дагуу 3 жил итгэмжлэл авдаг.	"Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавигдах ерөнхий шаардлага MNS ISO/IEC 17025:2018" стандартын шаардлага хангасан итгэмжлэлийн гэрчилгээ авсан байна.	Үйл ажиллагаа
Зорилт-2. Геодези, зураг зүйн цахим үйлчилгээ нэвтрүүлэх	Арга хэмжээ-1 Газар зүйн нэрийн мэдээллийн дэд систем хөгжүүлэх	Газар зүйн нэрийн мэдээллийн дэд систем	Монгол Улсын хэмжээнд 214805 газар зүйн нэр батлагдсан.	Газар зүйн нэрийн мэдээллийн дэд систем байгуулж, иргэд, байгууллагыг нэрийн лавлагаа, мэдээллээр хангах цахим систем нэвтрүүлнэ.	Улсын төсөв-80 сая төгрөг
	Арга хэмжээ-2	Байр зүйн зургийг нэгтгэж, засварлах	Геопорталаар дамжуулан хэрэглээнд	Байр зүйн зургийг нэгтгэж, засварлах цахим систем	Улсын төсөв 150 сая төгрөг

	Байр зүйн зургийн дэд систем хөгжүүлэх	хиймэл оюун ухаан бүхий цахим систем	нэвтрүүлэх боломж бүрдсэн.	нэвтрүүлсэн байна.	
	Арга хэмжээ-3 Дэвсгэр зургийн дэд систем хөгжүүлэх	Байр зүйн зургийг нэгтгэж, засварлах хиймэл оюун ухаан бүхий цахим систем	Геоорталаар дамжуулан хэрэглээнд нэвтрүүлэх боломж бүрдсэн.	Байр зүйн зургийг нэгтгэж, засварлах цахим систем нэвтрүүлсэн байна.	Улсын төсөв
	Арга хэмжээ-4 Геодезийн хэмжлийн багажны нарийвчлалыг шалгах, турших цахим үйлчилгээ нэвтрүүлэх	Импортээр оруулах бүх геодезийн багажны нарийвчлалыг шалгах, турших цахим систем	Геодезийн хэмжлийн багажийг баталгаажуулах цахим системийг 2024 онд хөгжүүлсэн.	Цахим үйлчилгээ бүрэн нэвтэрсэн байна.	Улсын төсөв-20 сая төгрөг
	Арга хэмжээ-5 Геодезийн сүлжээ, цэг, тэмдэгтийн цахим систем хөгжүүлэх	Геодезийн сүлжээ, цэг, тэмдэгтийн цахим систем	Геоорталаар дамжуулан хэрэглээнд нэвтрүүлэх боломж бүрдсэн.	Геодезийн сүлжээ, цэг, тэмдэгтийн цахим систем нэвтрүүлсэн байна. Системээс геоорталаар дамжуулан хэрэглэгчдэд үйлчилгээ үзүүлдэг болно.	Улсын төсөв
	Арга хэмжээ-6 Хил шалгалтын ажилд зориулсан цахим систем хөгжүүлэх	Хил шалгалтын ажилд зориулсан цахим систем	Улсын хилийн нэг дэх шалгалтын ажлын баримт цахим хэлбэрээр байхгүй, тоон хэлбэрт шилжүүлэх ажил хийгдсэн.	Хил шалгалтын ажилд зориулсан цахим систем нэвтрүүлж алдаагүй баримт бэлтгэх боломж бүрдсэн байна.	Улсын төсөв 300 сая төгрөг
	Арга хэмжээ-7 Геодези, зураг зүйн ажлын төсөв бодох цахим систем хөгжүүлэх	Геодези, зураг зүйн ажлын төсөв бодох цахим систем	“Геодези, зураг зүйн ажлын жишиг үнэ” Барилгын дүрмийг 2021 онд шинэчлэгдэн батлагдсан.	Цахим системээр дамжуулан Геодези, зураг зүйн ажлын төсвийн тооцоог бодож файлаар гаргах боломж бүрдсэн байна.	Улсын төсөв 40 сая төгрөг
Стратегийн зорилго 4: Олон улсын гэрээ хэлэлцээр хэрэгжүүлэх					
Зорилт-1. Улсын хил шалгалтын ажлыг зохион байгуулах	Арга хэмжээ-1 Монгол Улс, ОХУ хоорондын улсын хил шалгахад зориулан	3543 км урт улсын хил	Монгол Улс, ОХУ хоорондын улсын хилийг шалгаж, зураглах ажил 2023 оноос эхлүүлсэн.	Монгол-Оросын улсын хилийн дэглэмийн тухай Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын гэрээний хэрэгжилтийг хангаж УИХ-аар	Улсын төсөв-10,000 сая төгрөг

	геодези, зураг зүйн ажил хийх			батлуулах баримт бичгийг бэлтгэж батлуулсан байна.	
	Арга хэмжээ-2 Монгол Улс, БНХАУ хоорондын улсын хил шалгахад зориулан геодези, зураг зүйн ажил хийх	4709.6 км урт улсын хил	БНХАУ-ын талтай улсын хил шалгах ажлыг эхлүүлэх талаар 2024 оны 09 дүгээр сард тохирсон.	Монгол, Хятадын хилийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын гэрээний хэрэгжилтийг хангаж УИХ-аар батлуулах баримт бичгийг бэлтгэсэн байна.	Улсын төсөв-29,000 сая төгрөг
Үндсэн чиг үүргийн нэр: Улсын хэмжээнд газрын кадастрын бодлого боловсруулж, хэрэгжүүлэх, улсын газрын мэдээллийн санг бүрдүүлэх, хөтлөх					
Стратегийн зорилго 1: Хиймэл оюун ухаан, блокчейн технологийг ашиглан газар, үл хөдлөх хөрөнгийн хаягийн нэгдсэн системийг байгуулж, хэрэглээнд нэвтрүүлэх					
Зорилт-1. Хаягжуулалтын тухай хууль, эрх зүйн орчинг сайжруулан шинэчлэх	Арга хэмжээ-1 Хаягжуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, батлуулах	Хаягжуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл	Анхдагч хууль 2013 онд батлагдсан.	Улсын Их Хурлаар хэлэлцэж баталсан байна.	Урсгал зардал, үйл ажиллагаа
	Арга хэмжээ-2 Хаягжуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дагалдан гарах баримт бичгийг боловсруулж, батлуулах	Боловсруулсан баримт бичгийн тоо	Засгийн газрын 2019 оны 325, 2022 оны 180, 181 дүгээр тогтоол, MNS 5283-2022 стандарт	Холбогдох эрх бүхий байгууллагаар батлуулсан байна.	Урсгал зардал, үйл ажиллагаа

Зорилт-2. Гудамж, зам, талбай, үл хөдлөх хөрөнгийн хаягийн мэдээллийн нэгдсэн системийг байгуулж, хэрэглээнд нэвтрүүлэх	Арга хэмжээ-1 Олон Улсын стандартад нийцсэн Хаягийн мэдээллийн системийг шинэчлэн байгуулах, олон нийтэд нээлттэй байршилд суурилсан замчлалын системийг хөгжүүлэх, гудамж, нэгж талбар, барилга, байгууламжийг стандартын дагуу тэмдэгжүүлэх	Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн систем Хаягийн мэдээллийн сангийн зам заагч болон веб систем Гар утасны аппликэйшн	Хаягийн мэдээллийн систем 21 аймгийн хэмжээнд нэвтэрсэн.	Хаягийн мэдээллийн систем хэрэглээнд нэвтэрч хэвийн үйл ажиллагаа хангагдсан байна.	Улсын төсөв, төсөл хөтөлбөр 36,100.0 сая
	Арга хэмжээ-2 Дундын мэдээллийн сангаар дамжуулан төрийн байгууллагуудад нэгдсэн хаягийн мэдээллээр хангах	Сервисийн тоо	-	Төрийн байгууллагуудад нэгдсэн хаягийн мэдээллээр хангагдсан байна.	Урсгал зардал, үйл ажиллагаа
Стратегийн зорилго 2: Газрын кадастрын нэгдсэн системийн үйл ажиллагааг боловсронгуй болгож цахимаар үзүүлэх төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх					
Зорилт-1. Газрын кадастрын тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжийн эрх зүйн орчныг сайжруулах	Арга хэмжээ-1 Газрын ерөнхий хуулийн төслийг шинэчлэн боловсруулах, батлуулах, холбогдох судалгаа, тооцоог хийх ажлыг зохион байгуулж, Улсын Их Хуралд өргөн барих	Боловсруулсан хуулийн төсөл	Анхдагч хуулиуд 1997-2002 онуудад батлагдсан	Хуулийн төслийг боловсруулан батлуулах, холбогдох судалгаа, тооцоог хийх ажлыг зохион байгуулж, Улсын Их Хуралд өргөн барина. Улсын Их Хурлаар хэлэлцэж баталсан байна.	Урсгал зардал, үйл ажиллагаа

	Арга хэмжээ-2 Кадастрын тухай хуулийн төслийг шинэчлэн боловсруулах, батлуулах, холбогдох судалгаа, тооцоог хийх ажлыг зохион байгуулж, Улсын Их Хуралд өргөн барих	Боловсруулсан хуулийн төсөл	Анхдагч хуулиуд 1999 онд батлагдсан	Хуулийн төслийг боловсруулан батлуулах, холбогдох судалгаа, тооцоог хийх ажлыг зохион байгуулж, Улсын Их Хуралд өргөн барина. Улсын Их Хурлаар хэлэлцэж баталсан байна.	Урсгал зардал, үйл ажиллагаа
	Арга хэмжээ-3 Газрын кадастрын тухай хууль болон бусад холбогдох хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дагалдан гарах баримт бичгийг боловсруулж, батлуулах	Боловсруулсан баримт бичгийн тоо	-	Баримт бичгийг боловсруулж холбогдох эрх бүхий байгууллагаар батлагдсан байна	Урсгал зардал, үйл ажиллагаа
Зорилт-2. Газрын нэгдмэл санг эрхлэх, ГНСангийн цахим системийг хөгжүүлэх	Арга хэмжээ-1 Монгол Улсын хэмжээнд газрын нэгдмэл сангийн үйл ажиллагааг зохион байгуулж, газрын нэгдмэл санд гарч буй өөрчлөлт, шилжилт хөдөлгөөнийг бүртгэх, хянах, тайлагнах	Газрын нэгдмэл сангийн тооллого, бүртгэл хийх эрх зүйн орчин бүрдэж, өөрчлөлт, шилжилтэнд хяналт тавих, тайлагнах боломж бүрдсэн байна.	Улсын хэмжээнд газрын нэгдмэл сангийн ангилал, шилжилт хөдөлгөөний тайланг гаргасан.	Газрын нэгдмэл санд гарч буй өөрчлөлт, шилжилт хөдөлгөөнд хяналт тавих, тайлагнах боломж бүрдсэн байна.	Урсгал зардал, үйл ажиллагаа
	Арга хэмжээ-2 Монгол Улсын хэмжээнд төрийн байгууллагын уялдаа холбоог хангасан газрын нэгдмэл сангийн их өгөгдлийг бүрдүүлж, газар	Газрын нэгдмэл сангийн ангиллын шинэчилсэн тооллогыг хийж, улс, орон нутгийн томоохон бүтээн байгуулалт, шийдвэр гаргалтад шаардлагатай нэг	Газрын нэгдмэл сангийн цахим системийг улсын хэмжээнд нэвтрүүлсэн.	Газрын нэгдмэл сангийн их өгөгдөл бүрдэж, газар ашиглалтад хяналт тавих, дүн шинжилгээ хийх боломж бүрдсэн байна.	Улсын төсөв, 9,400.0 сая

	ашиглалтад хяналт тавих, дүн шинжилгээ хийх боломжийг бүрдүүлэх	эх үүсвэр бүхий мэдээлэл бүрдсэн байна.			
Зорилт-3. Газрын кадастрыг эрхлэх, төрөөс үзүүлж буй үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх	Арга хэмжээ-1 Газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн системээс авах үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй хүргэх	Хэрэглэгчийн тоо	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 110 дугаар тогтоолоор Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг улсын хэмжээнд хэрэглээнд нэвтрүүлсэн	www.egazar.gov.mn-ээс үйлчилгээ авсан хэрэглэгчийн хандалтыг 60 хувиар нэмэгдүүлсэн байна.	Урсгал зардал, үйл ажиллагаа
	Арга хэмжээ-2 Газрын нэгж талбарын түүхчилсэн лавлагааг цахимжуулах	Хэрэглэгчийн тоо	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 110 дугаар тогтоолоор Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг улсын хэмжээнд хэрэглээнд нэвтрүүлсэн	Газрын кадастрын мэдээллийн сангийн архивын лавлагаа мэдээлэлээр түргэн шуурхай хангагдах боломжтой болно	Урсгал зардал, үйл ажиллагаа
Стратегийн зорилго 3: Хиймэл оюун ухаан, блокчейн болон газар зүйн мэдээллийн системд суурилсан гурав, дөрвөн хэмжээст кадастрын мэдээллийн нэгдсэн системийг бий болгож хөгжүүлэх					
Зорилт-1. Гурав ба дөрвөн хэмжээст газрын кадастрын нэгдсэн системийг бий болгох	Арга хэмжээ-1 Суурь өгөгдөл болох гурван хэмжээст объектуудын архитектур мэдээллүүдийг бүрдүүлэх, цуглуулах	Өгөгдөл мэдээллийн тоо	Хот байгуулалтын кадастрын цахим системийг улсын хэмжээнд нэвтрүүлсэн.	Өгөгдөл мэдээлэл бүрдэж дүн шинжилгээ хийх боломж бүрдсэн байна.	Улсын төсөв, төсөл хөтөлбөр
	Арга хэмжээ-2 Гурав болон дөрвөн /3D, 4D/ хэмжээст Өгөгдлийн	Гурав болон дөрвөн /3D, 4D/ хэмжээст кадастрын мэдээллийн	"Улсын хэмжээнд гурав болон дөрвөн /3D, 4D/ хэмжээст кадастрын мэдээллийн нэгдсэн	Олон Улсын жишигт нийцсэн байх	Улсын төсөв, төсөл хөтөлбөр

	загварчлал ба мэдээллийн сангийн дизайныг гаргах, олон улсын жишигт нийцүүлэн боловсруулалт хийх	системийн загварчлах	системийг байгуулах, хэрэглээнд нэвтрүүлэх" техник эдийн засгийн үндэслэл хийгдсэн.		
	Арга хэмжээ-3 Цаасан болон цахим хэлбэрийн архитектур мэдээллээс гурван хэмжээст загвар үүсгэх программ хангамжийг судлах, турших /Revit болон Sketchup/	Гурав болон дөрвөн /3D, 4D/ хэмжээст кадастрын мэдээллийн нэгдсэн систем	"Улсын хэмжээнд гурав болон дөрвөн /3D, 4D/ хэмжээст кадастрын мэдээллийн нэгдсэн системийг байгуулах, хэрэглээнд нэвтрүүлэх" техник эдийн засгийн үндэслэл хийгдсэн.	Улсын хэмжээнд гурав болон дөрвөн /3D, 4D/ хэмжээст кадастрын мэдээллийн нэгдсэн системийг хийж, улс, орон нутгийн томоохон бүтээн байгуулалт, шийдвэр гаргалтад шаардлагатай нэг эх үүсвэр бүхий мэдээлэл бүрдсэн байна.	Улсын төсөв, төсөл хөтөлбөр 26,868.0 сая
	Арга хэмжээ-4 Газрын удирдлагын нэгдсэн систем болон төрийн байгууллагуудтай холбогдох	Сервисийн тоо	-	Төрийн байгууллагуудад нэгдсэн хаягийн мэдээллээр хангагдсан байна.	Урсгал зардал, үйл ажиллагаа
	Арга хэмжээ-3 Газрын удирдлагын нэгдсэн систем болон төрийн бусад байгууллагуудтай холбох	Сервисийн тоо	-	Төрийн байгууллагуудад нэгдсэн хаягийн мэдээллээр хангагдсан байна.	Урсгал зардал, үйл ажиллагаа
Үндсэн чиг үүргийн нэр: Газрын биржийн үйл ажиллагааг зохион байгуулах					
Стратегийн зорилго 1: Газрын биржийн үйл ажиллагааг зохих журмын дагуу удирдан зохион байгуулах, боловсронгуй болгох					
Зорилт-1 Газрын биржийн үйл ажиллагааг боловсронгуй болгож,	Арга хэмжээ-1 Цахим үйл ажиллагаатай газрын биржийг Газрын асуудал эрхэлсэн төрийн	Цахим үйл ажиллагаатай Газрын бирж	Цахим үйл ажиллагаатай газрын биржийг Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны	Цахим үйл ажиллагаатай газрын биржийг Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд	Улсын төсөв 108 тэрбум

үйл ажиллагааг өргөжүүлэх	захиргааны байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд байгуулах		байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд байгуулах ажлын ТЭЗҮ баталагдсан	байгуулсан байна.	
	Арга хэмжээ-2 Цахим үйл ажиллагаатай газрын биржийг Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд байгуулж, газар, үл хөдлөх хөрөнгө /ҮХХ/-ийн нэгдсэн системийг бий болгоно.	Цахим үйл ажиллагаатай Газрын бирж	Газрын биржийн цахим систем /www.mle.mn/-ийг улсын хэмжээнд нэвтрүүлсэн.	Цахим үйл ажиллагаатай газрын биржийг Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд байгуулж, газар, үл хөдлөх хөрөнгө /ҮХХ/-ийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлсэн байна.	
Зорилт-2 Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт явуулах зүйл ажиллагаа, биржийн үйл ажиллагааг сайжруулах, хэвийн үйл ажиллагааг хангах, боловсронгуй болгох	Арга хэмжээ-1 Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа зохион байгуулах журмыг боловсронгуй болгох, сайжруулах	Шинэчлэн баталсан Засгийн газрын тогтоол эсхүл нэмэлт өөрчлөлт оруулсан Засгийн газрын тогтоол	Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоол	Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа зохион байгуулах журмыг илүү боловсронгуй болж дуудлага худалаа амжилттай болох нөхцөл бүрдэнэ.	Улсын төсөв
	Арга хэмжээ-2 Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулах журмыг боловсронгуй болгох, сайжруулах	Шинэчлэн баталсан Засгийн газрын тогтоол эсхүл нэмэлт өөрчлөлт оруулсан Засгийн газрын тогтоол	Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоол	Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулах журмыг боловсронгуй болно.	Улсын төсөв
	Арга хэмжээ-3 Газрын биржийн үйл ажиллагааны журмыг	Шинэчлэн баталсан Засгийн газрын тогтоол эсхүл нэмэлт өөрчлөлт	Засгийн газрын 2016 оны 210 дугаар тогтоол	Газрын биржийн үйл ажиллагааны журмыг шинэчлэн боловсруулж батлуулсан байна.	Улсын төсөв

	шинэчлэн боловруулж, биржийн хэвийн үйл ажиллагааг хангах	оруулсан Засгийн газрын тогтоол			
Стратегийн зорилго 2: Газар, үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ, үнэ цэнийг нэмэгдүүлэх, төлбөр, татварыг оновчтой тогтоох, боловсронгуй болгох нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх					
Зорилт-1 Орчин үеийн техник, технологийг ашиглан газар, үл хөдлөх хөрөнгийн татвар, төлбөрийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн системийг хөгжүүлэх	Арга хэмжээ-1 Хиймэл оюун ухаан, блокчейн болон газар зүйн мэдээллийн системд суурилсан гурав болон дөрвөн хэмжээст газар, үл хөдлөх хөрөнгийн бүртгэл, үнэлгээ, татвар, төлбөрийн нэгдсэн системийг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлнэ.	Хиймэл оюун ухаан, блокчейн болон газар зүйн мэдээллийн систем, гурав болон дөрвөн хэмжээст газар, үл хөдлөх хөрөнгийн бүртгэл, Үнэлгээ, татвар, төлбөр	Газрын кадастрын мэдээллийн сангийн систем, Газрын үнэлгээ, төлбөр, татварын системийг улсын хэмжээнд нэвтрүүлсэн.	Гурав болон дөрвөн хэмжээст газар, үл хөдлөх хөрөнгийн бүртгэл, үнэлгээ, татвар, төлбөрийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлсэн байна	Улсын төсөв
	Арга хэмжээ-2 Дэвшилтэд технологид суурилсан гурван хэмжээст газар, үл хөдлөх хөрөнгийн системийг хөгжүүлнэ	Дэвшилтэд технологид суурилсан гурван хэмжээст газар, үл хөдлөх хөрөнгийн бүртгэл мэдээллийн нэгдсэн систем	Газрын кадастрын мэдээллийн сангийн систем	Дэвшилтэд технологид суурилсан гурван хэмжээст газар, үл хөдлөх хөрөнгийн бүртгэл мэдээллийн нэгдсэн системийг нэвтрүүлсэн байна	Улсын төсөв, төсөл хөтөлбөр
Зорилт-2 Газрын төлбөр, татварыг оновчтой тооцох эрх зүйн орчныг бий болгох	Арга хэмжээ-1 Ой, усны сан бүхий газрын хориглосноос бусад бүсэд газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгжийн газрын төлбөрийг хэмжээг нэмэгдүүлэн тооцох хууль эрх зүйн орчин бий болгоно	Шинэчлэн батлуулсан эсхүл нэмэлт өөрчлөлт оруулсан хууль	1997 онд батлагдсан Газрын төлбөрийн тухай хууль	Ой, усны сан бүхий газрын хориглосноос бусад бүсэд газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгжийн газрын төлбөрийг хэмжээг нэмэгдүүлэн тооцох эрх зүйн орчин бүрдсэн байна.	Улсын төсөв, төсөл хөтөлбөр

Стратегийн зорилго 3: Газар, үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ, үнэ цэнийг нэмэгдүүлэх газрын суурь үнэлгээг шинэчлэн тогтоох					
Зорилт-1 Газар, үл хөдлөх хөрөнгийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, зах зээлийн бодит үнэ цэнд суурилсан газрын суурь үнэлгээг тогтоох	Арга хэмжээ-1 Хот, тосгон бусад суурин газрын газрын суурь үнэлгээ болон зэрэглэл /бүс/-ийг шинэчлэн тогтоох	Шинэчлэн баталсан Засгийн газрын тогтоол	Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоол	Хот, тосгон бусад суурин газрын газрын суурь үнэлгээ болон зэрэглэл /бүс/-ийг шинэчлэн тогтоож Засгийн газраар батлуулсан байна.	Улсын төсөв
	Арга хэмжээ-2 Хөдөө аж ахуйн газрын үнэлгээний тойрог, газрын суурь үнэлгээг шинэчлэн тогтоох	Шинэчлэн баталсан Засгийн газрын тогтоол	Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоол	Хөдөө аж ахуйн газрын үнэлгээний тойрог, газрын суурь үнэлгээг шинэчлэн тогтоож Засгийн газраар батлуулсан байна.	Улсын төсөв
Зорилт-2 Газрын үнэлгээний зах зээлийн үнэлгээ хийх аргачлалыг олон улсын жишигт нийтцүүлэн илүү боловсронгуй болгох	Арга хэмжээ-1 Газрын зах зээлийн үнэ цэнийг тогтоох, олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгох	Шинэчлэн баталсан Засгийн газрын тогтоол	Засгийн газрын 2018 оны 181 дугаар тогтоол	Газрын зах зээлийн үнэлгээ хийх аргачлалыг олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгож батлуулсан байна.	Улсын төсөв
Үндсэн чиг үүргийн нэр: Газар ашиглалтад төрийн хяналтыг хэрэгжүүлэх, хамгаалах, нөхөн сэргээх ажлыг зохион байгуулах					
Стратегийн зорилго 1: Хяналт шалгалтын эрх зүйн орчныг сайжруулж, төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх					
Стратегийн зорилго 2: Хяналт шалгалтын нэгдсэн тогтолцоог бий болгож, хариуцлагатай газрын харилцааг бэхжүүлэх					
Зорилго-1. Газрын харилцааны салбарын хяналт шалгалтын эрх зүйн орчныг	Арга хэмжээ-1 Хяналт шалгалтын үйл ажиллагаа хэрэгжүүлэхэд шаардагдах баримт бичгийг шинэчлэн	Шинэчлэн батлагдсан эрсдэлийн шалгуур үзүүлэлт-1 Батлагдсан	2024 онд Салбарын хяналт шалгалтын объектыг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур үзүүлэлтийг шинэчлэн	Салбарын хэмжээнд мөрдөгдөж буй хяналт шалгалтын объектыг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур үзүүлэлт, шалгалтад	-

сайжруулах, нэгдсэн удирдлагаар хангах;	боловсруулах	хяналтын хуудас-1	боловсруулах журам", "Хяналт шалгалтын баримт бичгийг бүртгэх, дугаар олгох журмуудад нэмэлт өөрчлөлт оруулсан.	хамрагдах объектыг шалгах хяналтын хуудсыг шинэчлэн боловсруулж, хяналт шалгалтыг үр дүнтэй, ил тод, нээлттэй болгох, аливаа нөлөөллөөс ангид, адил тэгш, хараат бусаар хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлсэн байна.	
Зорилт-2. Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлж, газрын харилцааны салбарын хэмжээнд мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах.	Арга хэмжээ-1 Төлөвлөгөөт болон боловсруулж, газрын урьдчилан сэргийлэх, гүйцэтгэлийн хяналт шалгалт хийх	Хяналт шалгалтад хамруулсан объектын гүйцэтгэлийн хувь, Илэрсэн зөрчил арилалтын хувь, Хууль сахин мөрдөлтийн түвшин;	2024 онд хяналт шалгалтад хармагдах объектын 90 хувийг хамруулсан. Илэрсэн зөрчлийн 73,9%-ийг арилгуулсан. Хууль сахин мөрдөлтийн түвшин 78,1% байна.	Их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн объектод хяналт шалгалт хийж, эрсдэлийн түвшин болон хууль сахин мөрдөлтийн хувийг бууруулсан байна. Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлтийг бүрэн хангуулсан байна.	Улсын төсөв 185,0 сая төгрөг
	Арга хэмжээ-2 Улсын хэмжээнд газар өмчлөл, эзэмшил, ашиглах эрх олголтын байдал, салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийх;	21 аймгийн хяналт шалгалтын ажил гүйцэтгэсэн тайлан-21, Улсын хэмжээний нэгдсэн тайлан-1	2024 онд 21 аймгийн 41 сум, нийслэл, 9 дүүргийн хэмжээнд хяналт шалгалтын ажил гүйцэтгэж, тайланг Засгийн газрын хуралдаанд танилцуулсан.	21 аймгийн хэмжээнд эрх бүхий албан тушаалтны гаргасан захирамж, шийдвэрт хийсэн хяналт шалгалтын ажлын гүйцэтгэлд хяналт тавьж шаардлагатай засварыг хийлгүүлэх, хяналт шалгалтын ажлын аймгийн хэмжээний нэгдсэн тайлан боловсруулахад мэргэжил арга зүйгээр хангах; Орон нутагт томилолтоор ажиллаж 21 аймгийн 289 сумдын газар эзэмшил, ашиглалт, өмчлөлийн байдалд хяналт шалгалт хийх; Улсын хэмжээнд нэгдсэн тайлан боловсруулж	

				танилцуулга бэлтгэн газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх; МУ-ын Ерөнхий Сайдын байгуулсан ажлын хэсэг болон Засгийн газрын хуралдаанд танилцуулах.	
	Арга хэмжээ-3 Хяналт шалгалт хийхэд хэрэглэгдэх тоног төхөөрөмж, хэмжих хэрэгслийг шинэчлэх	Хэмжилт хийх таблет-1;	-	Хэмжилт хийх Artika таблетийг авсанаао сүлжээгүй үед хэмжилт хийх боломж бүрдэнэ.	Улсын төсөв 15.0 сая төгрөг
Зорилт-3. Төрийн хяналт шалгалтын мэдээллийн санг хөтөлж, хяналт шалгалтын нэгдсэн системийг бий болгох	Арга хэмжээ-1 Хяналт, удирдлагын нэгдсэн цахим систем (shilenkhyanal.gov.mn)-ийг хөтлөх	Системд бүртгэсэн хяналт шалгалтын мэдээний хэрэгжилт	Хяналт, удирдлагын нэгдсэн цахим системд 2024 онд газрын харилцааны салбарын хэмжээнд хийгдсэн хяналт шалгалтын мэдээллийг оруулсан.	Хяналт, удирдлагын нэгдсэн цахим системийг хөтөлж, салбарын хэмжээнд хийгдсэн хяналт шалгалтын тайлан, мэдээг системээс гаргах боломжийг бүрдүүлнэ.	-
	Арга хэмжээ-2 Газар, геодези, зураг зүйн хяналт шалгалтын нэгдсэн системийг бий болгох	Шинээр нэвтрүүлсэн систем	Газрын харилцааны салбарын хяналт шалгалтын нэгдсэн системийг шинээр боловсруулж, хэрэглээнд нэвтрүүлэхээр судалж байна.	Газрын харилцааны салбарын хяналт шалгалтын нэгдсэн системийг шинээр боловсруулж, хэрэглээнд нэвтрүүлсэн байна.	250,0 сая төгрөг
Стратегийн зорилго 3: Зайнаас тандан судлалын арга зүйг нэвтрүүлсэн газар ашиглалт, газрын мониторингийн байнгын ажиллагаатай хяналтын системийг хөгжүүлж, газрын доройтол, бохирдлыг шинжлэх ухааны үндэслэлтэй судлан тогтоож, нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэх, нэгдсэн мэдээллийн сан байгуулах					
Зорилт-1. Зайнаас тандан судлалын арга зүйг нэвтрүүлсэн газар ашиглалт, газрын мониторингийн	Арга хэмжээ-1 Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажлыг бүрэн цахимжуулж, өмчлөл, эзэмшил, ашиглалтад	Баталгаажуулсан дүгнэлтийн тоо, хамрагдсан талбайн хэмжээ, га-аар	Газрын монитонгийн цахим системийг 2020 хэрэглээнд нэвтрүүлсэн. 2024 оны байдлаар улсын хэмжээнд 67,000 орчим иргэн, хуулийн этгээд	Газрын төлөв байдал, чанарын захиалгат болон төлөвлөгөөт хянан баталгааны ажлын тайланг нэгтгэж, Засгийн газарт танилцуулсан байна.	Улсын төсөв, орон нутгийн төсөв, газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн өөрийн хөрөнгө

байнгын ажиллагаатай хяналтын системийг хөгжүүлж, газрын мониторингийн цахим системээр дамжуулан үйл ажиллагааг хэвийн тогтвортой эрхлэх, иргэд олон нийтийг мэдээллээр хангах	олгогдсон нийт газрын 60 хувьд, төрийн өмчийн бусад ангиллын газрын 50 хувьд газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны дүгнэлт гаргах ажлыг зохион байгуулах		өөрийн өмчлөл, эзэмшил, ашиглалтад байгаа газартаа төлөв байдал чанарын захиалгат хянан баталгааны дүгнэлт гаргуулсан. 2018 онд нийслэл, 17 аймгийн тариалан, атаршсан газрын ГТБЧУХБ-ны ажлыг 469,214.8 га талбайд, 2020-2024 онд улсын хэмжээнд 3000 цэгт хийж гүйцэтгэсэн.		
	Арга хэмжээ-2 Олон улсад хэрэглэгдэж байгаа зайнаас тандан судлалын арга зүй, шинэ цэс, модуль /toolbox, plugin, platform гэх мэт/-ийг судалж туршин газрын мониторингийн цахим систем, газрын мониторингийн үйл ажиллагаанд нэвтрүүлж, Монгол орны өргөн уудам газар нутагт техник, технологийн давуу талыг ашиглан богино цаг хугацаанд, жигд хүртээмжтэй байдлаар хяналт тавих	Газрын мониторингод ашигласан ургамлын болон газрын бүрхэвчийн зайнаас тандан судлалын индекс, багаж хэрэгслийн тоо болон ашигласан платформ, програмын хангамжийн тоо	2020 онд Газрын мониторингийн цахим системийг хэрэглээнд нэвтрүүлсэн. БХБС-ын 2022 оны 126 дугаар тушаалаар “Зайнаас тандан судлалын аргаар бэлчээрийн газрын мониторинг хийх аргачилсан заавар”, БХБС-ын 2023 оны 172 дугаар тушаалаар “Зайнаас тандан судлалын аргаар тариалангийн газрын мониторинг хийх аргачилсан заавар”-ыг тус тус батлуулж, хэрэглээнд нэвтрүүлсэн. АНУ-ийн Вискинсон-майдисоны Их Сургууль, МУИС-тай	Зайнаас тандан судлалын арга аргачлалыг туршин нэвтрүүлж, түүнд нийцүүлсэн системийн нэмэлт хөгжүүлэлт хийгдэж, зайнаас тандан болон газар дээрх судалгаа шинжилгээ хийж, нэгдсэн арга зүйгээр газрын мониторинг хийгддэг болсон байна. Газрын мониторингийн цахим систем мэдээллийн сангийн өгөгдөл мэдээллийг ашиглан машин сургалтын аргаар дүн шинжилгээ хийх модулийг хөгжүүлж, газрын мониторингийн үйл ажиллагаанд нэвтрүүлсэн байна.	Улсын төсөв, 1,005.0 сая

			хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан.		
Арга хэмжээ-3 Хөрсний хяналт- шинжилгээний лабораторийг аймаг, бүсүүдэд хувийн хэвшил барьж байгуулах, хүртээмжийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах	Монгол Улсын эдийн засгийн бүсүүдийг харгалзан үзэж байгуулсан магадлан итгэмжлэгдсэн лабораторийн тоо	Хөрсний хяналт шинжилгээний магадлан итгэмжлэгдсэн 8 лаборатори үйл ажиллагаа явуулж байна.	Баруун, зүүн, говь, төвийн бүсэд хамгийн багадаа 1 хөрсний лаборатори байгуулахад дэмжлэг үзүүлж ажилласан байна.	Үйл ажиллагаа	
Арга хэмжээ-4 Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа, газрын мониторингийн үйл ажиллагааны хүрээнд цуглуулсан мэдээнд дүн шинжилгээ хийж, илэрсэн газар ашиглалтын зөрчил, хохирол, бохирдлыг арилгах хариу арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх	Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажлын үр дүнгээр илэрсэн газар ашиглалтын зөрчил, бохирдол доройтолд өртсөн газрын байршил, талбайн хэмжээ, хариу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	2019 онд 15,000 цэг бүхий Газрын мониторингийн сүлжээг байгуулж, 2020-2024 онд нийт 3000 цэгт газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны судалгаа, шинжилгээ хийсэн.	Газрын мониторингийн цахим системийн мэдээллийн санд 4000 мониторингийн цэгт судалгаа, шинжилгээ хийж мэдээллийн санг шинэчилж, цуглуулсан мэдээнд дүн шинжилгээ хийж, газар ашиглалтын зөрчил, бохирдол доройтолд өртсөн эсэхийг шууд хянан боломжтой хяналтын тогтолцоог бүрдүүлсэн байна.	Улсын төсөв, 1,370.0 сая	

Зорилт-2 Газар хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, нэгдсэн мэдээллийн сан байгуулах	Арга хэмжээ-1 Доройтсон газрын байршил, хэмжээ, шалтгааныг тодорхойлох болон түүнийг нөхөн сэргээх журам, аргачлал, зааврыг боловсруулж хэрэглээнд нэвтрүүлэх хууль эрх зүйн орчныг сайжруулах	Газрын багц хуулийн төсөл, түүний үзэл баримтлалын төсөлд тусаж, батлагдсан заалтын тоо, Шинээр боловсруулж баталсан доройтсон газрыг тодорхойлох, түүнийг нөхөн сэргээх журам, аргачлал, зааврын тоо	ЗГ-ын 2024 оны 92 дугаар тогтоолоор “Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийх журам” батлагдсан. Доройтсон газрын байршил, хэмжээ, шалтгааныг тодорхойлох болон түүнийг нөхөн сэргээх аргачлалын төсөл боловсруулагдсан.	Доройтсон газрын байршил, хэмжээ, шалтгааныг тодорхойлох болон түүнийг нөхөн сэргээх үйл ажиллагаанд хариуцах этгээдүүд тодорхой болж, хийж гүйцэтгэх ажил, үе шат ойлгомжтой, салбар хоорондын уялдаа холбоо сайжирч, газар хамгаалах, нөхөн сэргээх тогтолцоо бүрдсэн байна.	Үйл ажиллагаа
	Арга хэмжээ-2 Маш хүчтэй болон хүчтэй доройтсон газрын байршил, хэмжээ, шалтгааныг газрын мониторингийн үйл ажиллагааны хүрээнд цуглуулсан мэдээнд дүн шинжилгээ хийж үнэлж, тогтоох, нөхөн сэргээх арга хэмжээг газар зохион байгуулалтын төлөвлөгөөгөөр дамжуулан хэрэгжүүлэх	Нийт газар нутгийн хэмжээнд газрын нэгдмэл сангийн ангиллын газарт хохирол учирсан газрын байршил, талбайн хэмжээ	2023 онд улсын хэмжээнд газар хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг нийт газар нутгийн 2.49 хувь буюу 3.89 сая га талбайд хэрэгжүүлсэн. /ГНСТ-10 маягт/	Хүчтэй элэгдэл, эвдрэлд орсон газарт нөхөн сэргээлт хийх төлөвлөгөө үе шаттай бүрэн хэрэгжиж, нөхөн сэргээлт хийгдсэн байна.	Улсын төсөв, орон нутгийн төсөв, 8,000.0 сая
	Арга хэмжээ-3. Доройтолд орж, хохирол учирсан газар болон нөхөн сэргээлт хийсэн газрын нэгдсэн	Газрын мониторингийн цахим системийн мэдээлл ийн санд мэдээлэл	2019 онд 15,000 цэг бүхий Газрын мониторингийн сүлжээг байгуулж, 2020-2024 онд нийт 3000 цэгт	Газрын төлөв байдал, чанарын өөрчлөлт, доройтлыг судалж тогтоох чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй бусад байгууллагуудыг нэгтгэсэн	Улсын төсөв, орон нутгийн төсөв, 1,000.0 сая

	мэдээллийн санг бий болгож, нөхөн сэргээлтийг үйл ажиллагааны хяналт, үнэлгээний тогтолцоог бүрдүүлэх	нь шинэчлэгдсэн орсон мониторингийн цэгийн тоо, нөхөн сэргээлтийн талбайд байгуулагдсан хяналтын мониторингийн цэгийн тоо	газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны судалгаа, шинжилгээ хийсэн	дундын мэдээллийн сан байгуулж, газрыг нөхөн сэргээх үйл ажиллагааг цахимжуулж, хэрэгжилтийн үе шатыг бүрэн хянах хяналтын системийг бий болгосон байна.	
Үндсэн чиг үүргийн нэр: Салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгох					
Стратегийн зорилго: Салбарын хууль тогтоомжийн төслийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлал, хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлэх хуулийн төслийг боловсруулж, батлуулах, холбогдох байнгын хороо болон Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлэх					
Зорилт-1. Салбарын хууль тогтоомжийг шинэчлэн боловруулах, батлуулах	Арга хэмжээ-1 Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх	Үнэлгээ хийсэн хууль тогтоомжийн тоо	-	8	Улсын төсөв
	Арга хэмжээ-2 Хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг боловсруулах, санал авах, олон нийтээр хэлэлцүүлэх, эрх бүхий байгууллагад өргөн барих, батлуулах ажлыг зохион байгуулах	Боловсруулсан хуулийн төслийн тоо	-	5	Улсын төсөв

	Арга хэмжээ-3 Салбарын хууль тогтоомж шинэчлэн батлагдахтай холбогдуулан шаардлагатай эрх зүйн бусад актыг шинэчлэн боловсруулах, батлуулах	Боловсруулсан эрх зүйн актын тоо	-	Хуульд батлахаар заасан хэм хэмжээний актыг бүрэн батлуулсан байх	Улсын төсөв
	Арга хэмжээ-4 Хууль тогтоомж сурталчлах	Иргэд, олон нийтэд хууль тогтоомжийг тухай бүр сурталчилсан эсэх	-		Улсын төсөв, бусад эх үүсвэр
Ерөнхий чиг үүргийн нэр: Байрлалд суурилсан орон зайн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэх, нийтэд үйлчлэх					
Үндсэн чиг үүргийн нэр: Байрлалд суурилсан орон зайн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлж, түгээх нэгдсэн систем бий болгох					
Стратегийн зорилго: Орон зайн өгөгдлийн дэд бүтцийг байгуулах, үйл ажиллагааг удирдан зохион байгуулах					
Зорилт-1. Орон зайн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэх хууль эрх зүйн орчинг бий болгох	Арга хэмжээ-1 Хуулийн төслийг боловсруулах, батлуулахаар Улсын Их Хуралд өргөн барина.	Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн төсөл	Хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг шинэчлэн боловсруулсан.	Улсын Их Хурлаар хэлэлцэж баталсан байна.	Урсгал зардал, үйл ажиллагаа
	арга хэмжээ-2 Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийг дагалдан гарах баримт бичгийг боловсруулж, батлуулахаар хүргүүлэх	Боловсруулсан баримт бичгийн тоо	-	Холбогдох эрх бүхий байгууллагаар батлагдсан байна.	Урсгал зардал, үйл ажиллагаа
Зорилт-2. Орон зайн өгөгдөл, мэдээллээр нийтэд үйлчлэх мэдээллийн системийг боловсронгуй болгох	Арга хэмжээ-1 Геопорталаар дамжуулан төрийн бодлого, төлөвлөлт, шийдвэр гаргалтын "Нэг газрын зураг", иргэд, олон нийт,	"Нэг газрын зураг", "Нээлттэй газрын зураг" цахим үйлчилгээ	Улсын хэмжээнд орон зайн өгөгдлийн дэд бүтцийн мэдээллийг нэгтгэж, цахим системийг үүсгэсэн	"Нэг газрын зураг" үндэсний гео-платформ байгуулна. "Нэг газрын зураг" үндэсний гео-платформийг шийдвэр гаргалт, цахим засаглалд ашиглана	Улсын төсвийн хөрөнгө оруулалт

	бизнесийн зориулалттай "Нээлттэй газрын зураг" цахим үйлчилгээг улсын хэмжээнд нэвтрүүлэх				
	Арга хэмжээ-2 Байрлалд суурилсан орон зайн өгөгдөл мэдээллийг терийн байгууллагуудын мэдээллийн сантай холбож, дундын мэдээллийн сан байгуулах	Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн журмын төсөл боловсруулагдсан.	-	Төрийн байгууллага хооронд байрлалд суурилсан орон зайн өгөгдөл мэдээллийг засварлах, баяжуулах, харилцан солилцох боломжийг бүрдүүлэх Дундын мэдээллийн санг байгуулсан байна.	Урсгал зардал, үйл ажиллагаа
Үндсэн чиг үүргийн нэр: Салбарын цахим систем, цахим үлчилгээний хэвийн, аюулгүй, найдвартай үйл ажиллагааг хангах					
Стратегийн зорилго: Салбарын өгөгдөл, мэдээлэл, түүнийг хадгалах, боловсруулах, дамжуулах төхник, тоног төхөөрөмж, программ хангамжийн аюулгүй, хэвийн, найдвартай үйл ажиллагааг хангах					
Зорилт-1. Төрийн үйлчилгээний ил тод байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлэх замаар салбарын хэмжээнд цахим шилжилт хийх үйл ажиллагааг дэмжих	Арга хэмжээ-1 Төрийн үйлчилгээний нэгдсэн системд салбарын үйлчилгээг холбох, байршуулах ажлыг асуудал эрхлэсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран зохион байгуулах	Цахим төрийн үйлчилгээний тоо	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 110 дугаар тогтоолоор үйл ажиллагаанд нэвтэрсэн Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системээс 42 үйлчилгээг цахим хэлбэр иргэн, хуулийн этгээдэд үзүүлж байна.	Засгийн газрын 2023 оны 100 дугаар тогтоолд заасан 28 үйлчилгээг Төрийн үйлчилгээний нэгдсэн системд бүрэн холбох	Урсгал зардал, үйл ажиллагаа
	Арга хэмжээ-2 Блокчейнд суурилсан Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим систем, орон зайн өгөгдлийн Геоортал цахим системийн	Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим систем, орон зайн өгөгдлийн Геоортал цахим систем	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 110 дугаар тогтоолоор Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг улсын хэмжээнд нэвтрүүлсэн.	Улсын хэмжээнд цахим системийг хэрэглээнд нэвтрүүлсэн байна.	Улсын төсвийн хөрөнгө оруулалт

	хөгжүүлэлт				
Зорилт-2. Салбарын хэмжээнд шинэ техник, технологийн шийдлийг нэвтрүүлэх замаар газрын харилцааны бүтээгдэхүүн, үйлчилгээний хэвийн, тасралтгүй, найдвартай үйл ажиллагааг хангах	Арга хэмжээ-1 Үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтцийн болон Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн нөөц дата төв	Нөөц дата төв	Үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтцийн болон Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн дата төв Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газарт байрлаж байна.	Нөөц дата төвийг хэрэглээнд нэвтрүүлсэн байна.	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
	Арга хэмжээ-2 Салбарын хэмжээнд цахим шилжилтийн үйл ажиллагаанд олон үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагаанд мэдээллийн аюулгүй байдлын стандарт /ISO27000 цуврал /ийг нэвтрүүлэх	1 стандарт	Салбарын хэмжээнд өгөгдөл, мэдээлэл, цахим системийн хэвийн ажиллагааг хангах дата төв ажиллаж байна.	ISO27001, ISO27002 стандартын шаардлагыг хангасан байна. Мэдээллийн технологийн аюулгүй байдал стандартын түвшинд хангагдаж эхэлсэн байна.	Хөрөнгө оруулалт, Урсгал зардал, үйл ажиллагаа
Ерөнхий чиг үүргийн нэр: Салбарын менежмент, хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх					
Үндсэн чиг үүргийн нэр: Салбарын нэгдмэл, төвлөрсөн удирдлагыг хэрэгжүүлэх					
Үндсэн чиг үүргийн нэр: Салбарын хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тогтвортой ажиллуулах бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх					
Стратегийн зорилго: Төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлж манлайлан ажиллах					
Зорилт-1. Хүний нөөцийн нэгдсэн цахим сан (төрийн албан хаагчийн хувийн	Арга хэмжээ-1 Салбарын хүний нөөцийн мэдээллийг тасралтгүй, тогтмол шинэчлэх	Хүний нөөцийн бүртгэл судалгааны чанартай байдал	2020 онд хүний нөөцийн дотоодын програм боловсруулсан.	Хүний нөөцийн судалгааг 7 хоног бүр шинэчлэх боломжтой болсон байна.	Үйл ажиллагаа

хэрэг, шилжилт хөдөлгөөн, сэлгэн ажиллуулах, шагнал урамшуулал, албан тушаалын өөрчлөлт, цол, зэрэг, дэв олгох гэх мэт үзүүлэлттэй байх) бүрдүүлнэ.					
Зорилт-2. Ажилтнуудын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг дээшлүүлэх чиглэлээр үе шаттай ажил зохион байгуулах замаар байгууллагын гүйцэтгэлийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ	Арга хэмжээ-1 Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	"Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр" 2020-2025-ийг баталсан.	Хөтөлбөрийг 90 хувьтай хэрэгжүүлсэн байна.	Үйл ажиллагаа
Зорилт-3. Гадаад, дотоод хамтын ажиллагааг хангах	Арга хэмжээ-1 Олон улсын мэргэжлийн байгууллагууд болон холбоодтой хамтын ажиллагааг өргөжүүлэн хамтарсан төслийг хэрэгжүүлэх	Хамтын ажиллагааны гэрээний тоо, хамтарсан төслийн хэрэгжилтийн түвшин	2024 онд нийт 5 улсын 8 байгууллагатай газар зохион байгуулалт, геодези, зураг зүй, мониторинг, орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагааны хүрээнд санамж бичиг байгуулсан.	Санамж бичгийн хүрээнд хийгдэх ажлуудын гүйцэтгэлийг бүрэн хангаж, олон улсын байгууллага, холбоодтой хамтын ажиллагаагаа өргөсгөн хамтарсан төсөл, хөтөлбөрийг үе шаттайгаар хэрэгжүүлсэн байна.	Үйл ажиллагаа, төсөл хөтөлбөр
Зорилт-4. "Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын хөтөлбөр"-	Арга хэмжээ -1 Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	Засгийн газрын 2019 оны 299 дүгээр тогтоолоор Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын хөтөлбөр	Хөтөлбөрийг 100 хувьтай хэрэгжүүлсэн байна.	Үйл ажиллагаа


ийн дагуу ажилтнуудыг сургалтад хамруулна	хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах		батлагдсан.		
Зорилт-5. Салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.	Арга хэмжээ-1 Захиргааны чиглэлээр эрх зүйн актуудын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, боловсронгуй болгох	Жил бүр 5-аас доошгүй эрх зүйн акт	Жил бүр 10 орчим эрх зүйн акт боловсруулж байна.	Нийт эрх зүйн актын 80 орчим хувийг шинэчилсэн байна.	Үйл ажиллагаа
Зорилт-6. Хяналт-шинжилгээ, үнэлгээ болон дотоод аудитын тогтолцооны чадавхийг бэхжүүлэх, үр нөлөөг дээшлүүлнэ	Арга хэмжээ-1 Аймгийн ГХБХБГ-ын болон Нийслэлийн Газар зохион байгуулалтын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх	2 жилд 1 удаа хяналт шинжилгээг хийсэн байна.	2 жилд 1 удаа хяналт шинжилгээ хийдэг.	Хяналт шинжилгээний ажил тогтмолжиж, үр нөлөө сайжирсан байна.	Томилолтын зардал
Зорилт-7. Олон нийтэд нээлттэй байгууллагын үйл ажиллагааг ил тод, нээлттэй байдлаар сурталчлан таниулж, зерэг хандлагыг нэмэгдүүлнэ.	Арга хэмжээ -1 Байгууллагын үйл ажиллагааг энгийн ойлгомжтой хэлбэрээр олон нийтэд хүргэх ажлыг өргөжүүлэх	Байгууллагын цахим хуудасны шинэчлэлтийн шуурхай байдал	Цахим хуудсан 2019 онд шинэчлэгдсэн.	Байгууллагын үйл ажиллагааны мэдээ олон нийтэд шуурхай хүрдэг болсон байна.	Үйл ажиллагаа
	Арга хэмжээ-2 Албан хэрэг хөтлөлтийн ажлыг зохион байгуулах	Баримт бичиг	2023 онд 4000 албан бичиг, 600 өргөдөл, гомдол хүлээн авсан	Газарт ирсэн, явсан, өргөдөл гомдолыг "Байгууллагын удирдлагын цогц цахим систем"-д бүртгэлжүүлж, тайлан мэдээг гаргасан байна.	Албан хэрэг хөтлөлтийн ажлыг зохион байгуулах
	Арга хэмжээ-3 Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах	Хадгаламжийн нэгж	Байгууллагын Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2023 онд 358 хадгаламжийн нэгж үүсгэсэн.	Байгууллагын архивт баримт хүлээн авах, бүртгэх, нягтлан шалгалт хийх, тоо бүртгэл хөтлөх, тооллого явуулах, хадгалах, хамгаалах, ашиглуулах, данс бүртгэл	Үйл ажиллагаа

				хөтлөх, устгах үйл ажиллагааг холбогдох журмын дагуу зохион байгуулсан байна.	
	Арга хэмжээ -4 Тусгай зөвшөөрөл болон мэргэжлийн байгууллагын эрх олгох, сунгах, хүчингүй болгох, хяналт тавих ажлыг зохион байгуулах	Системийн хөгжүүлэлт	2021 оноос Салбарын тусгай зөвшөөрөл. Мэргэжлийн байгууллын эрх олгох, тэдгээрт хяналт тавих системийг хэрэглээнд нэвтрүүлсэн.	Салбарын тусгай зөвшөөрөл. Мэргэжлийн байгууллын эрх олгох, тэдгээрт хяналт тавих системд хөгжүүлэлт хийж, хяналтыг сайжруулсан байна.	Үйл ажиллагаа
Стратегийн зорилго: Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн салбарын хөгжил, бодлогын үр нөлөөг дээшлүүлж, судалгаа, төлөвлөлтийн чанарыг сайжруулах					
Зорилт-1. Салбарын бодлого, салбар хоорондын уялдааг холбоог хангах, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах	Арга хэмжээ-1 Газар зохион байгуулалт, геодези, зураг зүй, орон зайн өгөгдлийн дэд бүтцийн бодлогын баримт бичгүүдийг нэгтгэн дүн шинжилгээ хийх	Нэгтгэн дүгнэсэн дүн шинжилгээний тайлангийн тоо	Монгол Улсын урт, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүд батлагдсан.	Салбарын стратеги, бодлогын баримт бичгүүдийн уялдаа, хэрэгжилт, эрх зүйн орчны бүрэн дүн шинжилгээг шинжлэх ухааны үндэслэлтэй хийж үр дүнг байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан байна.	Үйл ажиллагаа
	Арга хэмжээ-2 Салбарын болон бусад төрийн байгууллагуудын төлөвлөгөө, бодлогын баримт бичгүүдийн уялдааг хангах хурал, зөвлөлгөөн зохион байгуулах	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	Газрын харилцаа эрдэм шинжилгээний хурал жил бүр зохион байгуулагдсан.	Салбарын бодлогын баримт бичгүүд, төлөвлөгөөний уялдааг хангах зорилгоор бусад төрийн байгууллагууд, эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран зохион байгуулж үр дүнг нийтэлсэн байна.	Үйл ажиллагаа
Зорилт-2. Салбарын хүрээнд судалгаа шинжилгээний ажил эрхэлж, олон улсын	Арга хэмжээ-1 Газар зохион байгуулалт, геодези, зураг зүй, орон зайн өгөгдлийн дэд бүтэц, газрын мониторингийн	Судалгаа шинжилгээний баримт бичиг	-	Холбогдох талуудтай хамтран газрын харилцааны судалгаа шинжилгээний ажлыг зохион байгуулж, судалгааны материалыг байгуулагын	Үйл ажиллагаа

дэвшилтэт техник, технологийг хэрэглээнд нэвтрүүлэх	чиглэлээр судалгаа шинжилгээний ажил эрхлэх			албан хаагчид болон олон нийтэд хүргэсэн байна.	
	Арга хэмжээ-2 Олон улсын дэвшилтэт техник технологи, програм хангамжийн судалгааг хийн хэрэглээнд нэвтрүүлэх	Техник, технологи нэвтрүүлэх саналын төсөл	-	Газрын харилцааны салбарын хүрээнд техник, технологийн судалгаа хийж, хэрэглээнд нэвтрүүлэх болон ашиглалтын ур чадвар хөгжүүлэх санал бүхий төсөл боловсруулж, хэрэгжүүлсэн байна.	Үйл ажиллагаа, төсөл хөтөлбөр
Үндсэн чиг үүргийн нэр: Салбарын төрийн архивын сан хөмрөгийг бүрдүүлэх, бүртгэх, хадгалах, хамгаалах, ашиглах					
Стратегийн зорилго: Төрийн архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулах					
Зорилт-1. Архивын сан хөмрөгийн баримтыг тогтоосон журам, стандартын дагуу хадгалж, хамгаалах	Арга хэмжээ-1 Төрийн архивын зориулалтын байр бариулах	ТЭЗҮ	Байр барих газрын асуудлыг шийдвэрлүүлсэн	Төрийн архивын зориулалтын байр бариулах ТЭЗҮ боловсруулах	Урсгал зардал
	Арга хэмжээ-2 Төрийн архивын байрны зураг төсөл боловсруулах	Зураг төсөл	Байр барих газрын асуудлыг шийдвэрлүүлсэн	Зураг төсөл боловсруулах	Урсгал зардал
Зорилт-2. Архивын цахим системээр үйлчилгээ үзүүлэх	Арга хэмжээ-1 Архивын цахим системийн хөгжүүлэлт хийх	Системийн хөгжүүлэлт	2021 онд архивын цахим системийг бий болгосон.	Архивын цахим системийн хөгжүүлэлт хийж (нөхөн бүрдүүлэлтийн үйл ажиллагаа, үйлчилгээний хяналтын систем нэмэх) үйл ажиллагааг тогтмолжуулна.	Урсгал зардал
	Арга хэмжээ-2 Төрийн архивын түүхийн үнэт баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх, цахим үйлчилгээ үзүүлэх	Цахим системийн үйлчилгээ	Төрийн архивын баримтын 80% цахимжин цахим системд холбогдсон	Архивын цахим системээр үйлчилгээ үзүүлэх	Урсгал зардал

	Арга хэмжээ-3 Түүхийн үнэт баримтыг архивын хосгүй үнэт зүйлд бүртгүүлэх	Бэлтгэл ажил	1963-1990 онд агаараас авсан 1200 банк бүхий 354511 ширхэг гэрэл зургийн хальс төрийн архивт хадгалагдаж байна.	Төрийн архивт хадгалагдаж байна 1963-1990 онд агаараас авсан 354511 ширхэг гэрэл зургийн хальсыг цахимжуулж, хосгүй үнэт баримтад бүртгүүлэх	Хөрөнгө оруулалт Төсөл, хөтөлбөр
Үндсэн чиг үүргийн нэр: Салбарын хэмжээнд хууль тогтоомжоор хэрэгжүүлэх чиг үүргийг хэвийн, тасралтгүй, шуурхай явуулах нөхцөлийг бүрдүүлэх					
Стратегийн зорилго: Төрийн албан хаагчдыг нийтлэг үүргээ хэрэгжүүлэх нөхцөлөөр хангах, сайжруулах					
Зорилт-1. Салбарын хэмжээнд байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах, албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах	Арга хэмжээ-1 Компьютер, тоног төхөөрөмжийг сайжруулах	Батлагдсан төсвийн хүрээнд гүйцэтгэсэн ажлын тоо	2024 онд 598.6 сая төгрөгийн сервер, цахилгааны үүсгүүр, тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийсэн.	Байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах тоног төхөөрөмж худалдан авч, шинэчлэлт хийсэн байна.	Хөрөнгө оруулалт, Урсгал зардал
Зорилт-2. Газрын харилцааны байгууллагуудыг бүрэн өөрийн байртай болгох, хэвийн үйл ажиллагааг хангахад шаардагдах засварыг хийх	Арга хэмжээ-1 Улсын төсвөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын саналд тусгуулах, үе шаттайгаар шийдвэрлүүлэх Арга хэмжээ-2 Урсгал болон их засвар хийх	Батлагдсан төсвийн хүрээнд гүйцэтгэсэн ажлын тоо	2024 оны байдлаар 4 аймгийн ГХБХБГ аймгийн ЗДТГ-ын байранд үйл ажиллагаагаа явуулдаг. 2025 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын саналд 3 аймагт оффис, лабораторийн барилга шинээр барих, 1 аймагт конторын их засвар хийх саналыг тусган ЗГХЭГ-т хүргүүлсэн.	2025-2028 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөвт оффис, лабораторийн барилга шинээр барих, ажлыг тусгуулах, аймгуудын ГХБХБГ-ын хэвийн үйл ажиллагааг хангах урсгал болон их засварыг хийсэн байна.	Хөрөнгө оруулалт, Урсгал зардал

НАЙМ. СТРАТЕГИЙН ЗУРАГЛАЛ



ЕС. ХАВСРАЛТ

1. Салбарын өмнө тулгамдаж буй асуудал

№	Асуудал	Эрэмбэ
Нэг.Газар зохион байгуулалтын чиглэлээр		
1	Аймаг, сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний баримт бичиг боловсруулах болон хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг улс, орон нутгийн төсөвт тусгаж шийдвэрлэх хэрэгтэй;	Нэн их
2	Улсын хэмжээнд нийт 167 хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй сум байна. Үүнээс 2015 он болон түүнээс өмнөх онд боловсруулагдсан зарим төлөвлөгөөнүүд нийгэм, эдийн засгийн болон одоогийн газар олголтын байдалд хэрэгжих боломжгүй, тодотгох шаардлагатай, Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд орон зайн мэдээллийг бүртгэх боломжгүй зэрэг шалтгааны улмаас төлөвлөлтийн баримт бичигтэй уялдуулан газар олгох үйл ажиллагааг явуулах боломжгүй нөхцөл байдал үүссэн;	Их
3	Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлд зааснаас бусад газарт төлөвлөлтгүйгээр суурьшил үүсгэсэн. Аймаг, нийслэлийн ИТХ-аас нийслэл хот, хот, тосгон, бусад суурин газрын эдэлбэр газрын бүсчлэлийг тогтоож, бүсчлэлд тавигдах шаардлага, дүрмийг боловсруулан батлах шаардлагатай;	Их
4	Тусгай хамгаалалттай газар нутагт ашиглаж болох газар нутгийн хэсгийг тодорхойлж, төлөвлөсөн газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөг цахим системд бүртгэх. Мөн улсын тусгай хамгаалалттай газарт газар олгох, бүртгэлжүүлж, гэрчилгээжүүлэх асуудлыг газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системээр дамжуулан хэрэгжүүлэх хэрэгтэй;	Их
5	Хууль болон норм, дүрэмд хамгаалалтын бүсийг тогтоох асуудлыг заасан байх боловч аймаг, нийслэлийн ИТХ болон Засаг дарга бүрэн эрхээ хэрэгжүүлэхгүй хамгаалалтын бүсийг тогтоохгүй байгаа зэрэг шалтгаанаас цахим системд мэдээллийг оруулах боломжгүй, улсын хэмжээнд нэгдсэн мэдээллийн сан байхгүй байна;	Нэн их
6	Бусад төрийн байгууллагуудын бодлого төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан дэд бүтэц, бүтээн байгуулалтын төсөл хөтөлбөрийн нэгдсэн мэдээллийн сан байхгүйгээс давхардсан төлөвлөлт хийгдэж салбар хоорондын зөрчил үүсэх эрсдэлтэй байна;	Нэн их
7	Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийн эргэлтийн цэгийг байгалийн хил зааг, тоот өндөрлөг, газар зүйн нэр болон хүний гараар бүтээгдсэн тодорхой объектоор тогтоосон байдаг нь үндэслэлгүйгээр хилийн цэсийн маргаан үүсэх гол шалтгаан болж байна. Мөн аймаг, сум, нийслэл, дүүргийн хилийн цэсийг шинэчлэн тогтоохдоо хил залгаа сумдын хилийн цэсийг тогтоосон зарлиг, тогтоолыг шинэчлэн батлаагүйгээс зарлиг, тогтоолын давхцал үүсэх, давхцуулан газар олгох асуудал үүсэж байна. Иймээс Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд бүртгэлтэй хилийн цэсийн эргэлтийн цэсүүдийн солбицлыг УИХ-ын тогтоолоор батлах шаардлагатай.	Нэн их
Хоёр.Геодези, зураг зүйн чиглэлээр		
	Монгол Улсын өндрийн сүлжээний нарийвчлалыг сайжруулах, нутаг дэвсгэрийн хэмжээнд өндрийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх, улсын батлан	

1	хамгаалах, аюулгүй байдал, дэд бүтэц, эдийн засаг, шинжлэх ухааны хэрэгцээ шаардлагыг өндөр нарийвчлалтай өгөгдлөөр хангах, геодезийн хэмжилт, бүх төрлийн масштабын байр зүйн болон дэвсгэр зураглалын ажлын өндрийн үндэслэлийг өндөр нарийвчлалтай тодорхойлох шаардлагатай боловч улсын төсөв батлагддаггүй. Үүнээс шалтгаалан шалтгаалан Засгийн газрын хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт хангалтгүй;	Их
2	Нийт нутаг дэвсгэрийн 55%-ийг 1:25000-ны масштабтай байр зүйн зургаар зурагжуулаагүй, ТЭЗҮ хийгдсэн боловч зураг хийгдээгүй. Жил бүр төсвийн тооцоо гаргаж сангийн яам руу хүргүүлдэг боловч төсөв батлагдахгүй байгаа;	Их
3	Монгол улсын гравиметрийн тулгуур сүлжээг байгуулснаас хойш 40 жилийн дараа абсолют гравиметрийн хэмжилтийг гравиметрийн эхлэл болон тулгуур 3 цэг дээр 2024 онд хийсэн. Монгол улсад мөрдөгдөж байгаа барилгын норм ба дүрэмд гравиметрийн тулгуур сүлжээг 5-8 жил тутамд давтан хэмжих, түүнчлэн хүчтэй газар хөдлөлт, галт уулын дэлбэрэлт болсон эсвэл хүндийн хүчний хурдатгалын өөрчлөлтөд нөлөөлж болох байгалийн бусад хүчтэй үзэгдлүүд болсны дараа давтан хэмжилтийг хийх шаардлагатай гэж заасан боловч улсын төсөв батлагддаггүй;	Нэн их
4	GNSS-ийн байнгын ажиллагаатай суурин станцын сүлжээг өтгөрүүлж 63 станцтай болгон ТЭЗҮ 2023 оны 11 сард батлагдсан боловч улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэн хэрэгжүүлэх ажлын жагсаалтаас хасагддаг. Одоо хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа Геодези, зураг зүйн хуульд GNSS-ийн станцын асуудал холбогдох зүйл заалт тусгагдаагүй учраас эрхзүйн орчин бүрдээгүй зэрэг асуудал нь уг ажлын урт болон дунд хугацааны бодлого төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй гол асуудал болж байна;	Нэн их
5	“Улсын хэмжээнд 1:1000-ны масштабтай байр зүйн зураг хийх” ТЭЗҮ боловсруулж 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн Геодези, зураг зүйн ОТБМЗ-ийн хурлаар, 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдөр ДДЗХ-аар хэлэлцүүлж дэмжигдсэн. Ажлын даалгаврын төслийг нэгжийн дарга нараар хянуулан газрын даргаар АД2024/32 дугаартай батлуулж 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 1/703 дугаар албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн боловч төсөв хасагддаг. Үүнээс шалтгаалан хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт хангалтгүй байна;	Их
6	Монгол улсад бүх төрлийн масштабтай байр зүйн зураглал үйлдэхэд ашиглаж буй нисгэгчгүй нисэх төхөөрөмжийн тоон камерын зөвшөөрөгдөх алдааны нарийвчлалаа хангаж байгаа эсэхийг хянах боломжгүй байна;	Дунд
8	Монгол Улсын хэмжээнд 214805 газар зүйн нэр батлагдсан. Олон зуун жилийн түүхтэй уламжлалт газар зүйн нэр мартагдах болсон төдийгүй дур мэдэн шинээр нэр өгөх, өөрчлөх хэвлэл мэдээлэл, ном товхимол, газрын зурагт янз бүрээр бичиж нийтлэх асуудлууд гарч байна. Газар зүйн нэрийг иргэн, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх үүднээс газар зүйн нэрийн мэдээллийн дэд систем хөгжүүлэх шаардлагатай боловч улсын төсөв батлагддаггүй.	Нэн их
Гурав.Кадастрын чиглэлээр		
1	Иргэн, хуулийн этгээд өсөн нэмэгдэж байгаа зах зээлийн эдийн засгийн хүрээнд газрыг олон зориулалтаар ашиглах болсон бөгөөд одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Газрын тухай хууль болон бусад холбогдох хуульд зарим харилцааг зохицуулаагүйн улмаас иргэн, хуулийн этгээдийн газрын эрхийн баталгаа хангагдахгүй эрсдэлтэй нөхцөл байдал үүсэж байна. Иймд Газрын тухай хуулийг шинэчлэн боловсруулж, батлуулах хэрэгцээ шаардлага тулгараад байна;	Нэн их

2	Газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах ажил эрчимжсэнээр зөвшөөрөлгүй газар ашиглалт түүнийг дагаад нэмэгдэж байна. Иймд зөвшөөрөлгүй газар ашиглалтад хяналт тавих тогтолцоог улам боловсронгуй болгох асуудал тулгараад байна;	Их
3	Газартай холбоотой аливаа эрхийг олон байгууллага, албан тушаалтны шийдвэрээр олгож, цаашлаад кадастрын зураглал хийж бүртгэх асуудлыг харилцан уялдаа холбоогүй, нэгдсэн стандартгүй хийж байгаа нь газрын сан нэгдмэл байх зарчим болон төрөөс баримталж буй газрын харилцааны талаарх бодлого, түүний хэрэгжилт, төрийн өмчийн газрын хамгаалалт, хяналт, хариуцлагын тогтолцоог алдагдуулж, улмаар газар, үл хөдлөх эд хөрөнгийг эрхийн кадастрын бүртгэлд бүрэн хамруулахгүй байх нөхцөл байдалд хүргэж байна;	Их
4	Хаяг олгох үйл ажиллагааг 4-5 байгууллага эрхэлдэг байсан нь задгай болон түр хаяг олгох, давхардаж хаяг олгох, хаягийн иж бүрдэл дутуу, хаяг олгох шат дамжлага олон, хаягийн мэдээлэл нь нэгдсэн стандартгүй нь улмаас Улсын хэмжээнд хаягийн мэдээллийг ашиглахад хүндрэл учруулж байна;	Нэн их
5	Газрын кадастрын мэдээллийн цахим системийн хэвийн үйл ажиллагааг хангах, албан хаагчдын ашиглаж буй интернэт, сүлжээний хурд, техник тоног төхөөрөмжид шинэчлэлт хийх шаардлагатай байна;	Дунд
6	Газрын кадастрын системийг бүрэн автоматжуулж, гурав ба дөрвөн хэмжээст кадастрын системийг байгуулж олон улсын жишигт нийцүүлэх шаардлагатай;	Дунд
7	Иргэд, олон нийтийн газрын талаарх хууль, эрх зүйн мэдлэг дутмаг, мөн мэдээллийн хүртээмжгүй байдлаас шалтгаалж газрын талбайн хэмжээг дур мэдэн өөрчлөх, бусад иргэн, хуулийн этгээдэд олгогдсон газарт давхцал үүсгэх, газрын эрхээ баталгаажуулалгүйгээр хашаа хатгах гэх мэт газрын зөрчил маргаан үүсэх нөхцөлийг бүрдүүлж байна.	Дунд
Дөрөв.Газрын бирж, үнэлгээ, төлбөрийн чиглэлээр		
1	Хүний нөөцийн хүрэлцээ хангалтгүй. Тухайлбал, 21 аймгийн ГХБХБГ-т газрын төлбөр, тавар, үнэлгээ, биржийн асуудлыг 1 мэргэжилтэн хариуцаж 3 системийг өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж байгаа бөгөөд ажлын ачаалал өндөр байна. Мөн Газрын биржийн хэлтэс 3 мэргэжилтэнтэй 21 аймаг, 330 сум, нийслэл, дүүргийн газрын төлбөр, татвар, үнэлгээ, биржийн асуудлыг хариуцах бөгөөд тус бүр нэг нэг систем хариуцаж хэвийн үйл ажиллагаа явуулахад хүндрэлтэй байна;	Дунд
2	Газрын бирж, газрын төлбөр, үнэлгээний цахим системийн хэвийн үйл ажиллагааг хангахад техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх, хүчин чадлыг нэмэгдүүлэх, нэмэлт хөгжүүлэлтийг тогтмол хийх шаардлагатай. Тухайлбал, дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтын оролцогчийн тоо нэмэгдэхийн хэрээр тус системийн сүлжээний болон өгөгдөл боловсруулалтын ачаалал нэмэгдэж, дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтын явцад удаа дараа алдаа гарч тус системийн хэвийн үйл ажиллагааг хангах боломжгүй нөхцөл байдал үүсэж байна. Мөн улсын хэмжээний нэгж талбаруудад хуулийн хугацаанд газрын төлбөр, татварын ногдуулалт, нэхэмжлэхийг үүсгэхэд системийн хүчин чадал хүрэлцдэггүй. Улмаар бусад системийн хэвийн үйл ажиллагаанд нөлөөлж байна;	Дунд
3	Хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, шинэчлэх. Тухайлбал, Газрын биржийн орлого, зарлагыг хэрхэн шийдвэрлэх талаар нарийвчлан тусгах, газрын сан байгуулах, газар хөгжүүлэлт хийх, шаардлагатай тохиолдолд дуудлага худалдааны оролцогчийг түр хугацаагаар хязгаарлах асуудлуудыг хуульд тусгах хэрэгтэй.	Их

Тав.Орон зайн өгөгдөл, мэдээллийн чиглэлээр		
1	Өгөгдлийн нарийвчлал, үнэн зөв байдал: Зарим орон зайн өгөгдөл хуучирсан, эсвэл алдаатай байна;	Их
2	Стандартын зөрүү: Өгөгдөл нь нэгдсэн стандарт, форматтай байхгүйгээс системүүдийн уялдаа холбоо муу байна;	Их
3	Хүртээмж муу: Байгууллагууд орон зайн өгөгдлийг хаалттай ашигладаг нь өгөгдөл солилцоог хязгаарлаж байна;	Их
4	2. Хуучин системүүд: байгууллагууд хуучирсан программ хангамж, тоног төхөөрөмж ашиглаж байна;	Дунд
5	3. Өндөр өртөгтэй технологи: Шинэчлэгдсэн дэвшилтэт технологийг нэвтрүүлэхэд санхүүгийн асуудалтай тулгардаг;	Дунд
6	Кибер аюулгүй байдал: Өгөгдлийн хадгалалт, дамжуулалтын аюулгүй байдал хангалтгүй.	Дунд
Зургаа.Санхүү, эдийн засгийн чиглэлээр		
1	Санхүүжилт дутмаг: Засгийн газрын болон хувийн хэвшлийн санхүүжилт хангалтгүй; Улсын төсөв болон орон нутгийн төсвийн санхүүжилт хангалтгүй;	Дунд
2	Төсвийн буруу хуваарилалт: Эрэмбэлэлтийн бодлогогүйгээс хөрөнгө оруулалтын үр дүн муу; Салбарын хэмжээнд хөрөнгө оруулалтын ажлыг эрэмбэлэн ажлаа төлөвлөдөг боловч төсөв батлагддаггүй.	Их
Долоо.Газрын мониторинг, нөхөн сэргээлтийн чиглэлээр		
1	Иргэд, хуулийн этгээд өөрсдийн өмчилж, эзэмшиж, ашиглаж байгаа газрынхаа төлөв байдал, чанар, газраа зөв зохистой ашиглах хамгаалах чиглэлээр нэгдсэн ойлголтгүй байгаа нь газар ашиглалтын зөрчил, газрын бохирдол, доройтолд өртөх нөхцөлийг бүрдүүлж байна;	Их
2	Хүний нөөц - Газрын мониторингийн хэлтсийн мэргэжилтнүүд болон 21 аймгийн мэргэжилтнүүд, сумын даамлууд богино хугацаанд /оролцоогоор 1-2 жил/ солигдож байгаа нь газрын мониторинг, нөхөн сэргээлтийн үйл ажиллагааг тогтвортой эрхлэхэд хүндрэл үүсгэж байна;	Их
3	Санхүүжилтээс шалтгаалж Газрын тухай хуулийн 58 дугаар зүйлд заасны дагуу 5 жил тутамд бүх ангиллын газарт газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлыг зохион байгуулахад хүндрэлтэй байна. Мөн газрын нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа нь хэрэгжүүлэхэд хөрөнгө мөнгө их шаардлагатай байдаг тул орон нутагт хэрэгжихэд хүндрэлтэй байна;	Нэн их
4	Улсын хэмжээнд ихэнх сумдад бэлчээрийн газрын фотомониторингийн хээрийн судалгааг хийх багаж тоног, төхөөрөмж хуучирч муудсан тул зайлшгүй шинэчлэх шаардлагатай;	Дунд
5	Газрын мониторинг, нөхөн сэргээлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон бусад байгууллагуудын үйл ажиллагааг нэгдсэн байдлаар зохицуулах хууль эрх зүйн орчин бүрдээгүй журам, заавар, аргачлал байхгүй байгаа нь нэгдсэн байдлаар мониторинг хийх, газар хамгаалах нөхөн сэргээх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байна.	Дунд
Найм. Төрийн захиргаа, удирдлагын чиглэлээр		
1	Төрийн байгууллагууд хоорондын уялдаа холбоо хангалтгүй;	Нэн их

2	Сурч боловсрох цаг хугацаа бага;	Дунд
3	Шинэ санал, санаачилгыг дэмжих хандлага харилцан адилгүй;	Дунд
4	Бодлогын баримт бичгийг судлах, ашиглах байдал хангалтгүй.	Дунд
Ес.Салбарын хяналт шалгалтын чиглэлээр		
1	Салбарын хяналт шалгалтыг хэрэгжүүлэхэд төсөв хөрөнгийн дутагдалтай. 2025 оны төсөвт агентлагийн хэмжээнд тодорхой төсөв тусгагдсан ч орон нутагт хангалтгүй байгаа;	Нэн их
2	Салбарын хяналт шалгалт хэрэгжүүлэх нэгжийн албан хаагчдын орон тоо хүрэлцэхгүй ачаалал их байгаа;	Дунд
3	Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад эрх бүхий албан тушаалтан нь иргэн хуулийн этгээдээс мэдүүлэг авах болон мэдээллийг хадгалах, хамгаалах орчин, нөхцөл бүрдээгүй.	Дунд
Арав. Салбарын архивын чиглэлээр		
1	Төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журмын 6-р зүйлийн дагуу тоноглогдсон нууцын өрөөг тохижуулан, нууцын үйл ажиллагааг хэвийн явуулах шаардлагатай;	Их
2	Агаарын гэрэл зургийн хальсыг тоон хэлбэрт шилжүүлэх төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, фото сканнертай болох хэрэгтэй;	Дунд
3	Архивын баримтын хадгалалт, хамгаалалтын орчныг сайжруулах;	Дунд
